



Агуулга

Нэг. Компанийн товч танилцуулга.....	3
1.1.Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйл.....	3
1.2.Зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц.....	4
Хоёр. Хангах үйл ажиллагаа	7
2.1.Худалдан авсан цахилгаан эрчим хүч	7
2.2.Борлуулсан цахилгаан эрчим хүч	8
2.3 .Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал	10
2.4 .Цахилгаан эрчим хүчний орлого	11
2.5. Цахилгаан эрчим хүчний авлага	11
2.6. Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр	12
Гурав. Түгээх үйл ажиллагааны чиглэлээр	25
3.1. Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын ажил.....	25
3.2 Урсгал засвар	32
3.3 Эргүүл үзлэг.....	34
3.4 Бэлэн байдал шалгасан талаар.....	35
3.5 Аянгын улирлын бэлтгэл ажлын талаар.....	35
3.6 Тасралт	36
3.7 Захиалгат тасралт.....	39
3.8 Гэмтэл	42
3.9 Дуудлага барагдуулалт.....	49
3.10 Энерги баланс	52
3.11 Горим ажиллагаа.....	53
3.12 Хяналт хэмжилт.....	66
Дөрөв. Хяналт шинжилгээ, аюулгүй ажиллагааны чиглэлээр	67
4.1. ISO45001:2018 ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоо хэрэгжилт	67
4.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хяналт.....	72
4.3. ХАБЭА-н дасгал сургууль явуулсан талаар	73
4.4. Мэргэшлийн ээлжит шалгалтын талаар	75
4.5. Аюул илрүүлэлт устгалтын талаар	76
4.6. Технологийн зөрчлийн талаар	77
4.7. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалтыг сайжруулах талаар .	78
4.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардлын талаар.....	79




4.9. Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын талаар	81
4.10 Хяналт шалгалт	82
4.11 Хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажил	84
4.12. Өргөдөл гомдол.....	84
Тав. Мэдээлэл технологийн чиглэлээр.....	86
5.1 Мэдээллийн аюулгүй байдал чиглэлээр	86
5.2 НЕС-д хийгдсэн ажлууд	89
5.3 Сервер орчны чиглэлээр	93
5.4 Борлуулалт арилжааны системийн талаар.....	94
5.5 Хүний нөөцийн програм хангамжийн талаар	96
5.6 Диспетчерийн хяналтын системийн талаар	96
5.7 Мэдээлэл холбоо, сүлжээний талаар	99
5.8 Ухаалаг тоолуур	100
Зургаа. Олон нийт, хэвлэл мэдээллийн ажлын чиглэлээр.....	102
6.1.Олон нийтийн ажлын талаар.....	102
6.2.Хэвлэл мэдээллийн чиглэлээр.....	106
6.4. Гэрээ, Журмын төсөл боловсруулах, баталгаажуулах, хяналт тавих ..	111
6.5. Бичиг баримтыг бүртгэх, боловсруулах талаар	113
6.6. Сургалт хөгжлийн талаар	114
6.7. Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд	116
Долоо. Шинэ санал, санаачлага	117
Найм. Дүгнэлт.....	122

Нэг. Компанийн товч танилцуулга

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн дагуу Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК нь Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудын 26 сумын 74000 км² нутаг дэвсгэрт орших 4435 аж ахуйн нэгж, 44491 айл өрх, нийт 48926 хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч түгээх, хангах үйл ажиллагааг Монгол Улсын Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Улсын Стандартчилал Хэмжилзүйн Төвөөс олгосон 9 тусгай зөвшөөрөл, лицензийн дагуу явуулж байна. Үүнд:

- 1) Цахилгаан түгээх
- 2) Цахилгаанаар зохицуулалттай хангах
- 3) 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар
- 4) Туршилт тохируулгын ажил үйлчилгээ /2-догч коммутацийн ажлууд болон хэмжилт туршилт тохируулгын бүх төрлийн ажлууд/
- 5) Бусад дагалдах ажил үйлчилгээ /өрлөг дулаалга бэхэлгээ болон тулгуур хийц хэсгийн үйлдвэрлэлт, нийлүүлэлт/
- 6) 0.1-100МВт-ын эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах
- 7) Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 110кВ-оос дээш
- 8) ЦЭХ-ний 1 ба 3 фазын тоолуурын шалгалт, тохируулга, суурилуулах
- 9) Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих



1.1. Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйл

Уриа - **ГЭРЛИЙН ХУРДААР ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ...**

Алсын хараа - Эрчим хүчийг дэвшилтэт технологиор хэрэглэгчдэд...

Эрхэм зорилго - Чадварлаг хүний нөөцөд тулгуурлан аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэвшилтэт технологийн нэвтрүүлэн, хэрэглэгчээ дээдэлсэн, салбартаа тэргүүлэгч үйлчилгээний байгууллага болно.

Үнэт зүйл - **Д**эвшилтэт технологи, **С**этгэл зүтгэл, **Ц**огц чадамж, **Т**өгөлдөршил, **С**ахилга бат, **Х**эрэглэгчийн итгэл, **К**омпанийн засаглал
Тэргүүлэх чиглэл – Техник технологи, Хүний нөөц, Хөгжил, Өсөлт, Аюулгүй ажиллагаа, Хэрэглэгч

ҮНДСЭН ЗОРИЛТ:

- 1) Дэлхийн жишигт хүрсэн техник, технологи, IT программ хангамжийг ашиглаж, хөгжүүлнэ.
- 2) Санал санаачлагатай, өөриймсөг, бүтээлч шийдэлтэй нэгдмэл чадварлаг сэтгэл зүтгэлтэй хамт олон байна.

3) Дэвшилтэт технологи, чадварлаг хүний нөөцтэй хэрэглэгчдийнхээ хүсэлт тэмүүллийг мэдэрдэг, өндөр бүтээмж цогц чадамжтай компани болно.

4) Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд осол аюулгүй, түргэн шуурхай хүргэж борлуулалтын орлого, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлнэ.

5) Аюул, эрсдэлийг илрүүлж, арилган аюул эрсдлээс сэргийлэх зөв дадал хэвшил эзэмшүүлж, осол зөрчилгүй ажиллана.


6) Харилцагч, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлж, харилцан итгэлцэл, хүндлэлийг бий болгон ажиллана.

7) Бид ирээдүй болон цаашдын хөгжил дэвшилд бодлогыг тодорхойлж, ажилтан албан хаагчийн эрх ашгийг дээдэлсэн, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага ухамсарласан компани байна.


1.2. Зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц

Бодлого зохицуулалтын 5 хэлтэс, мэдээлэл технологи, шуурхай удирдлага, засвар туршилт, хэмжүүр тоолуур, тээвэр үйлчилгээний чиглэлээр ажиллах 5 алба, тоног төхөөрөмжийн ашиглалт борлуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх 4 салбар, 2 төвтэйгээр нийт 442 ажилтан ажиллахаас нийт 426 ажилтан байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж байна.

ДСЦТС ХК-ийн БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





Нийт ажилтнуудын 31,5 хувийг эмэгтэйчүүд, 68,5 хувийг эрэгтэйчүүд тус тус эзэлж байна.




Нийт ажилтнуудаас компанид 45,6 хувь нь 0-5 жил, 27,2 хувь нь 6-10 жил, 10,2 хувь нь 11-15 жил, 7,3 хувь нь 16-20 жил, 9,7 хувь нь 21-ээс дээш жил тус тус ажилласан ажилтнууд эзэлж байна.

Нийт ажилтнуудаас 36 хүртэлх насныхан 259 ажилтан буюу 61.2 хувь, 36-аас дээш насныхан 164 ажилтан буюу 38,8% тус тус эзэлж байна. Компанийн ажилтнуудын дундаж наслалт 35,5 нас байна.



36 хүртэлх насны ажилтнуудын 2012-2019 оны дээрх судалгаанаас харахад компанийн ажилтнууд жил ирэх тусам залуужиж байна.



Компанийн хэмжээнд 158 удирдах болон ИТА /албан хаагч/ байдаг ба үүнээс Эрчим хүчний зөвлөх инженер 3, мэргэшсэн инженер 3, мэргэшсэн төсөвчин 1, мэргэшсэн нябо 1 зэрэг мэргэшлийн зэрэгтэй ажилтнууд, мөн 48,5 % нь дээд боловсролтой ажилтнууд эзэлж байгаагаас 22 магистр зэрэгтэй ажилтнууд, 16 ажилтан гадаадад мэргэжил, боловсрол эзэмшсэн байна.

➤ Компанийн 2019 оны хүний нөөцөд бүртгэлтэй байгаа 103 иргэний анкет болон компанийн ажилтнуудын боловсрол, ажилласан жил, туршлагыг харгалзан “Сул чөлөөтэй болон эзгүй орон тоонд ажилтан

сонгон шалгаруулж ажилд авах журам”-ын дагуу Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 28 иргэнийг ажлын байраар ханган хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийг хийж ажиллалаа.

➤ Хүний нөөцийн програмд 2019 онд шинээр ажилд орсон 41 ажилтнуудын анкет, ажлын байр өөрчлөгдсөн 50 ажилтан, ажлаас чөлөөлөгдсөн 59 ажилтаны бусад дэлгэрэнгүй мэдээллийг оруулан баяжилтыг тухай бүрд нь хийн, програмаас шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайланг гарган ажиллаж байна.


Хүний нөөцийн хөдөлгөөн /шинээр ажилд орсон/

Шинээр ажилд орсон							
1	Ангилал	Мэргэжил	Бүгд	Дээд сургуулиас	Тусгай дунд сургуулиас	Мэргэжлийн сургуулиас	Мэргэжлийн курсээс
		Бүгд	35	11	6	14	4
1	Компанид	Цахилгааны	25	9	5	11	
2		Жолооч	6			2	4
4		Эрх зүйч	1	1			
5		Сувилагч	1		1		
6		Бусад	2	1		1	

Хүний нөөцийн хөдөлгөөн /ажлаас чөлөөлөгдсөн/


№	ШАЛТГААН	Тоо
1	Өөрийн хүсэлтээр /шилжилт хөдөлгөөн-5, эрүүл мэнд-2, өөр ажилд орох-18, сурахаар-2, бусад-9/	36
2	Жирэмсний болон амаржсаны амралт авсан	9
3	Хөдөлмөрийн дотоод журмын зөрчлөөр	6
4	Тэтгэвэрт гарсан	8
	Нийт ажилчдын тоо	59

2015-2019 онд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудыг графикт харуулбал:



Хоёр. Хангах үйл ажиллагаа

2.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч



2019 онд Нэг худалдан авагчаас 443,5 сая кВт*цаг цахилгаан эрчим хүч худалдан авахаас 476,8 сая кВт*цаг цахилгаан эрчим хүч худалдан авч төлөвлөгөөнөөс 7,5%-р буюу 33,3 сая.кВт.цагаар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 8,1%-р буюу 38,5 сая.кВт.цагаар өссөн байна.

Он	Хэмжих нэгж	Өссөн дүн
2018 оны гүйцэтгэл	сая.кВт.ц	438.2
2019 оны төлөвлөгөө	сая.кВт.ц	443.5
2019 оны гүйцэтгэл	сая.кВт.ц	476.8
Өмнөх оны гүйцэтгэлээс	биет	38.5
	хувь	8.1%
Тухайн оны төлөвлөгөөнөөс	биет	33.3
	хувь	7.50%

Тайлант хугацаанд хүлээн авсан цахилгаан эрчим хүчний 54,3% буюу 259,1 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг шинийн үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагууд хүлээн авсан бол 45,6% буюу 217,6 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг харъяа салбар нэгжүүд хүлээн авсан байна.

Салбаруудын ХАЦЭХ-ний хэмжээ 217,6 сая.кВт.цаг болсон бөгөөд өнгөрсөн оны мөн үеээс 8,4 сая кВт цагаар буюу 4,0 хувиар өссөн байна



Д/Д	Салбар хэсгийн нэр	ХАЦЭХ /сая.кВт.ц/			
		2018	2019	2018/2019	
				биет	хувь
1	Дархан-ХҮТ	109.0	113.8	4.8	4.4%
2	Сүхбаатар	41.0	42.1	1.1	2.7%
3	Зүүнхараа	31.2	32.7	1.5	5.0%
4	Жаргалант	16.1	16.8	0.8	4.8%
5	Хөтөл	12.1	12.3	0.22	1.8%
	Дүн	209.2	217.6	8.4	4.0%

Худалдаж авсан цахилгаан эрчим хүч




2.2 Борлуулсан цахилгаан эрчим хүч

Тайлант хугацаанд гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөөгөөр 411,0 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулахаас 428,5 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулж өмнөх оны мөн үеэс 47,7 сая кВт.цагаар өсөж төлөвлөгөөний биелэлт 104,3% боллоо.




Салбаруудын борлуулсан цахилгаан эрчим хүч:

Борлуулсан цахилгаан эрчим хүч							
Хэмжих нэгж	ББЗХ	ХҮТ	Сүхбаатар	Зүүнхараа	Жаргалант	Хөтөл	Нийт
сая.кВт.ц	246.00	96.86	33.38	27.81	13.95	10.56	428.5
Эзлэх хувь	57%	23%	8%	6%	3%	2%	100%



2.3.Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал




Тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний нийт алдагдал 10,11% буюу 48,1 сая.кВт.цаг болсон нь төлөвлөгөөт алдагдал /13,90%/ 3,79 нэгжээр буюу 20,5 сая.кВт.цагаар буурсан, өмнөх оны гүйцэтгэлээс 3,0 нэгжээр буюу 9,3 сая.кВт.цагаар буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 3,0 нэгжээр алдагдал буурсан байна.

Он	Хэмжих нэгж	Сарууд												Өссөн дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
2018 оны гүйцэтгэл	%	16.88	9.54	13.05	13.47	9.95	13.31	8.04	15.13	16.23	14.8	6.6	18.8	13.11
2019 оны төлөвлөгөө	%	17.58	12.23	15.55	13.35	12.25	11.41	9.78	13.42	13.69	14.3	14.8	17.9	13.90
2019 оны гүйцэтгэл	%	14.04	1.33	26.44	7.50	12.77	-1.44	14.62	5.44	7.40	23.7	-9.2	15.9	10.11
Төлөвлөгөөнөөс	%	-3.5	-10.9	10.9	-5.9	0.5	-12.9	4.8	-8.0	-6.3	9.4	-23.9	-2.0	-3.8
Өмнөх оны гүйцэтгэлээс	%	-2.8	-8.2	13.4	-6.0	2.8	-14.8	6.6	-9.7	-8.8	8.9	-15.7	-2.9	-3.00


Түгээлтийн алдагдал өмнөх оны гүйцэтгэлээс 9,3 сая кВт.цагаар буурсан байна.

Он	Хэмжих нэгж	Сарууд									Өссөн дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	
2018 оны гүйцэтгэл	сая.кВт.ц	5.7	2.7	4.4	4.7	3.4	4.9	2.7	5.8	6.3	40.7
2019 оны төлөвлөгөө	сая.кВт.ц	6.0	3.5	5.3	4.7	4.3	4.2	3.3	5.2	5.7	42.2
2019 оны гүйцэтгэл	сая.кВт.ц	5.0	0.4	9.3	3.0	5.6	-0.6	6.5	2.0	2.9	34.1
Төлөвлөгөөнөөс	сая.кВт.ц	-1.0	-3.1	4.0	-1.7	1.3	-4.8	3.1	-3.1	-2.8	-8.2
Өмнөх оны гүйцэтгэлээс	%	-0.7	-2.3	4.9	-1.7	2.2	-5.5	3.7	-3.7	-3.4	-6.6



2.4.Цахилгаан эрчим хүчний орлого

Гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөөний дагуу 70,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 72,4 тэрбум төгрөгийн орлого цуглуулж гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөө 102,2% гүйцэтгэлтэй байна.




Цуглуулсан орлогын 62% буюу 32,6 тэрбум төгрөг шинийн борлуулалтаас, 38% буюу 19,7 тэрбум төгрөг нь салбар хэсгүүдийн борлуулалтаас төвлөрсөн байна.

Цуглуулсан орлого							
Хэмжих нэгж	ББЗХ	ХҮТ	Сүхбаатар	Зүүнхараа	Жаргалант	Хөтөл	Нийт
сая.кВт.ц	44862.6	14823.7	4911.6	4196.8	2162.1	1488.9	72445.7
Эзлэх хувь	62%	20%	7%	6%	3%	2%	100%

2.5. Цахилгаан эрчим хүчний авлага

Хэрэглэгчээс авах цахилгаан эрчим хүчний авлага 2352.2 сая төгрөг болж оны эхний үлдэгдлээс 167.3 сая төгрөгөөр буурсан байна.

Цахилгаан эрчим хүчний авлагыг бүтцээр ангилан авч үзвэл нийт авлагын 1% буюу 16.3 сая төгрөгийг төсвийн авлага, 95% буюу 2395.5 сая төгрөгийг ААНБ-н авлага, 4% буюу 104.7 сая төгрөгийг ахуйн авлага эзэлж байна.



2019 онд компанийн хэмжээнд айл өрхийн авлага 16,4 сая төгрөг буюу 13,54 хувиар буурсан. Үйлдвэр аж ахуйн нэгжийн авлага 164,2 сая төгрөг буюу 6,86 хувиар буурсан байна.

Ангилал	2018	2019	Өссөн дүн	
			өсөлт (+), бууралт (-)	
			биет	хувь
ТӨСӨВ	3,003,100	16,297,056	13,293,956	442.67%
ААН	2,395,496,390	2,231,226,414	-164,269,976	-6.86%
АХУЙ	121,087,633	104,687,576	-16,400,057	-13.54%
ДҮН	2,519,587,123	2,352,211,046	-167,376,077	-6.64%

2.6. Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр

ДСЦТС ХК нь “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлөөс тодорхойлсон үйл ажиллагааны чиглэлийг мөрдөж компанийн дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэх боломж нөхцөлүүдийг судлах, үр ашигтай хэрэглэх талаар компанийн ажилтнууд болон хэрэглэгчид мэдлэг, мэдээлэл олгох, ЦЭХ-ний түгээлтийн алдагдал бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах зэрэг эрчим хүчний хэмнэлттэй холбоотой хууль дүрэм журам тогтоол шийдвэрийг биелүүлэн ажиллалаа.

2019 онд Эрчим хүч хэмнэх, алдагдал бууруулах чиглэлээр төлөвлөсөн ажилаас бизнес төлөвлөгөөний тодотголоор 11 ажил хасагдаж бусад 54 ажил 100 хувийн гүйцэтгэлтэй бүрэн хийгдсэн.

Тус Цахилгаан эрчим хүчний алдагдал бууруулах, эрчим хүч хэмнэх чиглэлээр хийх ажилд 2450,4 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэл 95 хувь буюу 2319,7 сая төгрөгний зардал гарч төлөвлөсөн зардалдаа бүрэн гүйцэтгэсэн.

1. Цахилгаан эрчим хүчний алдагдлыг бууруулж эрчим хүч хэмнэх чиглэлээр хийгдсэн ажил:


Компани нь “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-д заасан үүргийн дагуу цахилгаан эрчим хүчний алдагдлыг бууруулах чиглэлээр 2019 оны их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөгөөнд тусгаж агаарын шугам, тоноглолыг сайжруулж цахилгаан эрчим хүчний алдагдалыг бууруулах зорилгоор 6/0,4 кВ-ын 10 дэд станцад 1645,7 сая төгрөг төлөвлөж 1329,7 сая төгрөгний зардалтай доорхи ажлыг хийж гүйцэтгэсэн.

1. Дархан-Уул аймагт 9.4км, Сэлэнгэ аймагт 50.2км, Төв аймагт 5.1км нийт 15 дэд станцын 64.7км 0.4кВ-ын агаарын шугамыг төмөр бетон тулгуур бүрээстэй дамжуулагчаар шинэчлэх, шинээр барих ажил хийсэн.


2. 0,4кВ-ын агаарын шугамын шинэчлэлийн ажлаар Сэлэнгэ аймгийн Баянгол, Цагааннуур, Алтанбулаг, Түшиг, Түнхэл, Зүүнбүрэн, Мандал, Орхонтуул, Хүдэр, Номгон, Дархан-Уул аймгийн Шарын гол, Орхон, Хонгор, Дархан, Төв аймгийн Жаргалант, Цээл, Борнуур, Заамар сумын 522км урт 0,4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон тулгуур, бүрээстэй багц дамжуулагч утастайгаар шинээр барьсан.

3. Хүдэр сум АТП-108 дэд станцын 0,4кВ-ын 5км агаарын шугам модон тулгуур СИП утсаар сольж тоолуур төвлөрүүлэх ажил хийсэн.

4. Сэлэнгэ аймгийн Ерөө суманд Ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж АТП-102, 103, 117, 135, ТП-4 дэд станцуудын 0,4кВ-ын ЦДАШ-ыг шинэчилсэн. Энэ ажлын хүрээнд 870ш төмөр бетон тулгуур босгож, 30000м СИП утас татаж, 620ш ухаалаг тоолуур суурилуулсан.



Эрчим хүч хэмнэх, цахилгаан эрчим хүчний алдагдал бууруулахаар их засвар, ТЗБАХ, зохион байгуулалтын арга хэмжээгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд компанийн ЦЭХ-ний түгээлтийн алдагдал 10,11 хувь болж тайлант оны зорилтот төлөвлөгөөнөөс 3,8 нэгжээр буюу 18,1 сая кВт цагаар бууруулж эрчим хүч хэмнэгдсэн.



Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 он төлөвлөгөө	2019 он гүйцэтгэл	Алдагдлын бууралт / хэмнэлт/
Худалдан авсан ЦЭХ	сая кВтц	476.8	476.8	0.0
ЦЭХ-ний алдагдал	биет	сая кВтц	66.3	-18.1
	хувь	%	13.90%	-3.8%

Тайлант оны цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдалыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 3,0 нэгжээр буюу 9,2 сая кВт цагаар алдагдал бууруулж борлуулалтын орлогыг 1,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.




Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он гүйцэтгэл	2019 он гүйцэтгэл	Алдагдлын бууралт / хэмнэлт/
Худалдан авсан ЦЭХ	сая кВтц	438.2	476.8	38.6
ЦЭХ-ний алдагдал	биет	сая кВтц	57.4	-9.2
	хувь	%	13.11%	10.11%

ЦЭХ-ний алдагдлын бууралтаар хэмнэгдсэн эрчим хүчийг хүлэмжийн хийд шилжүүлж тооцвол 2919,0 тн жишмэл түлш, 5930,7 тн бодит түлш хэмнэж 8431,1 тн хүлэмжийн хий агаар мандалд цацагдахаас сэргийлсэн байна.

Үзүүлэлт	Алдагдал бууруулсан ЦЭХ /сая кВт цаг/	Жишмэл түлшний хэмнэлт /тн/	Хэмнэх бодит түлш/тн/	Хүлэмжийн хийн бууралт /тн/
Төлөвлөгөөнөөс бууралт	18.1	5742.9	11668.0	16587.2
Өмнөх жилээс бууралт	9.2	2919.0	5930.7	8431.1

2019 онд хэмнэсэн бодит болон жишмэл түлш, бууруулсан хүлэмжийн хий



Жишмэл түлшний хэмнэлт /тн/ Бодит түлшний хэмнэлт/тн/ Хүлэмжийн хийн бууралт /тн/

2. Дотоод хэрэгцээний Эрчим хүч, ус, дулааны хэрэглээг бууруулах чиглэлээр хийгдсэн ажил:

Компанийн дотоод хэрэгцээг хэмнэх чиглэлээр 2019 оны Эрчим хүч хэмнэх ажлын төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, ТЗБАХ-ын төлөвлөгөөнд тусгаж доорхи ажлуудыг хийсэн.

1. 2019 оны Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийх төлөвлөгөөнд тусгасны дагуу компанийн төв офиссын бодлогын хэлтэс, албад болон коридорын хуучин гэрэлтүүлгийг 80 ширхэг Эрчим хүчний хэмнэлттэй ЛЕД гэрлээр 6-р сард сольсон.


Гэрэлтүүлэг сольсноор жилд 20,2 мян кВт цаг ЦЭХ хэмнэж 3,2 сая төгрөгийн зардал хэмнэгдэж өртгөө жилийн хугацаанд нөхнө.

Тооцоог хүснэгтээр харуулав.

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх	Дараа
			ЛЕД	ЛЕД
1	Гэрлийн тоо	ш	80	80
2	Чадал	Вт	144	55
3	Жилдажиллахцаг	цаг	2880	2880
4	Жилд хэрэглэх цахилгаан	мян.кВт.ц	33.2	12.672
5	Цахилгааны үнэ	төг/кВт.ц	154.4	154.4
6	Цахилгааны төлбөр	мян.төг	5123.2	1956.8
	Хэмнэлт жилд	мян.кВт.ц		-20.5
		мян.төг		-3166.4
	LED гэрлийн үнэ	мян.төг		40.0
	LED гэрлийнтөлбөр	мян.төг		3200.0
	Өртөгөөнөхөхугацаа	жил		1.0



2. Компанийн 6 кВ-ын хуваарилах байгууламж, 6/0,4кВ-ын хаалттай дэд станцууд, офиссын барилгын дулаан алдалтыг бууруулж дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч хэмнэх зорилгоор дараах засвар, дулаалгын ажлуудыг хийсэн. Компанийн авто машины граж болон офиссын дулаан алдалтыг бууруулах зорилгоор граж, офиссыг холбосон хонгил хоолойд давхар металл хаалга хийсэн.




Мөн төв конторын гражийн дээврийн засварын ажилыг бүрэн хийж, гражын модон цонхыг вакум цонхоор сольж дулаан алдалтыг бууруулсан.



Салбарын 6 кВ-ын ХХБ, 6/0,4кВ-ын дэд станцуудын барилгын дээвэр, гадна хаалга солих, хаяавч цутгалтын ажлыг хийж дулаан алдалтыг багасгасан байна.



3. 35/6 кВ-ын дэд станцуудын тосон таслуурын бак, приводны орос улсад үйлдвэрлэсэн 500Вт-ын 96 ширхэг халаагуурыг хятад улсад үйлдвэрлэсэн 300Вт-ын 48 ширхэг халаагуураар сольсон.



Ингэснээр хүйтний улиралд халаагуурын зарцуулж буй ЦЭХ-ний хэрэглээг 24,2 мян кВт цаг хэмнэж зардлыг 3,7 сая төгрөгөөр бууруулж өртгөө 2 сард нөхөх тооцоо гарч байна.

Халаагуур сольсноор ЦЭХ хэмнэх тооцоо:

Д/д	Үзүүлэлт	Хэмжихнэгж	Тосон таслуурын Халаагуур	
			ӨмнөхОрос	ДарааОрос
1	Халаагуурын тоо	ш	96	48
2	Чадал	кВт	0.5	0.3
3	Жилд ажиллах цаг	цаг	720	720
4	Жилд хэрэглэх цахилгаан	мян.кВт.ц	34.6	10.4
5	Цахилгааны үнэ	төг/кВт.ц	154.4	154.4
6	Цахилгааны төлбөр	мян.төг	5336.7	1601.0
	Хэмнэлт жилд	мян.кВт.ц		-24.2
		мян.төг		-3735.7
	Халаагуурын үнэ	мян.төг		792.0
	Өртөгөө нөхөх хугацаа	жил		0.2

4. 6кВ-ын хувиарилах байгууламж болон дэд станцуудад шинээр тавигдсан халаагуурын цаг болон температурын тохируулгыг хийлгэсэн.



35/6кВ-ын дэд станцууд болон 6кВ-ын РП-ний халаагуурын цаг температурын тохируулгын судалгаа


№	Диспетчерийн нэрхаяг	Халаагуур тохируулах	
		Цаг	Температур
1	РП-11	08:00-10:00 12:00-14:00 16:00-17:00 22:00-01:00 04:00-06:00	t=15°C
2	35/6кВ Хараадэдстанц		
3	35/6кВ Чулуункарьер		
4	35/6кВ Элсэнкарьер		
5	35/6кВ Ханжаргалан		
6	РП-4		
7	РП-6		
8	РП-3		
9	РП-20		
10	РП-12		
11	РП-13		
12	РП-10		
13	ТП-20		
14	РП-1		
15	РП-2		
16	РП-5		
17	РП-8		
18	РП-9		
19	РП-7		
20	РП-99		

Компанийн Цахилгаан эрчим хүч, Дулаан, Усны дотоод хэрэгцээний хэрэглээ 2019 оны дүнгээр 344,8 сая төгрөг болж өмнөх оны гүйцэтгэлээс 30,3 сая төгрөгөөр зардалаа бууруулж хэмнэсэн байна.

он	Дотоод хэрэгцээний зардал / сая төгрөг/			Нийт дүн
	Цахилгаан	Дулаан	Ус	
2018 он	263.9	66.5	44.7	375.1
2019 он	260.1	62.7	21.9	344.7
бууралт	-3.8	-3.8	-22.8	-30.4

ЦЭХ-ний хэмнэлт гаргаж зардал буурсан нь 6кВ-ын ХХБ, 6/0,4кВ-ын дэд станц, контор офиссын гэрэлтүүлэг, халаагуурыг эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилттэй тоноглол хэрэгслээр сольж, ажилтнуудад хэмнэх чиглэлээр зөвлөмж, сурталчилгаа хийж компанийн салбар нэгжүүдийн дотоод хэрэгцээний гүйцэтгэлийг сарын ажлын үр дүн тооцох журамд тусгаж дүгнэж байгаатай холбоотойгоор дотоод хэрэгцээ буурч байна.

Компанийн дүнгээр 2019 онд компанийн оффисс, дэд станцуудад 241 ширхэг ЛЕД гэрэлтүүлэг, 20 ширхэг тохируулгатай халаагуур суурилуулсан. Эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай дэвшилтэт ЛЕД гэрэлтүүлэгт 5,4 сая төгрөг, халаагуурт 3,6 сая төгрөг зарцуулж 2019 оны гүйцэтгэлээр 270,3 мян кВт цаг хэмнэж 3,8 сая төгрөгөөр зардал буурсан байна. Дээрхи гарсан үр дүнгээр өртөгөө нөхөх хугацаа үр ашгийг тооцвол 2,3 жилд өртөгөө нөхөхөөр байна.



Дотоод хэрэгцээний гүйцэтгэлийг салбар нэгжээр нь задалж харвал:

Цахилгаан эрчим хүчний дотоод хэрэглээ:

№	Нэгжийн нэр	Цахилгааны хэрэглээ						
		2018 он		2019 он		өсөлт/+, бууралт/-		
		кВт цаг	төгрөг	кВт цаг	төгрөг	кВт цаг	төгрөг	хувь
1	Тээвэр үйлчилгээ аж ахуйн алба	245,617	37928110	212,022	38335624	-33,595	407,514	-13.68%
2	Засвар туршилт тохируулгын алба	294,999	45553706	263,211	47591121	-31,788	2,037,415	-10.78%
3	Дархан хэрэглэгчид үйлчлэх төв	82,827	12790124	51,056	9231419	-31,771	-3,558,705	-38.36%
4	Сүхбаатар салбар	217,088	33522774	206,373	37314388	-10,715	3,791,614	-4.94%
5	Зүүнхараа салбар	472,138	72907510	389,831	70485358	-82,307	-2,422,152	-17.43%
6	Хөтөл салбар	112,916	17436468	84,957	15361123	-27,959	-2,075,345	-24.76%
7	Жаргалант салбар	283,354	43755596	231,158	41795671	-52,197	-1,959,925	-18.42%
	Дүн	1,708,939	263,894,288	1,438,608	260,114,704	-270,331	-3,779,584	-15.82%



3. Эрчим хүч хэмнэх чиглэлээр компанийн ажилтнууд болон хэрэглэгчдэд мэдлэг мэдээлэл, сургалт хийгдсэн ажилууд:

1. Эрчим хүчний хэмнэлтийн тухай ойлголт, хууль эрх зүйн орчин, эрчим хүч хэмнэх боломж, арга хэрэгслүүдийн талаар мэдлэг олгох зорилгоор компанийн 380 орчим ажилтан, төсвийн 11 байгууллагын 260 орчим ажилтанд мөн хүсэлт ирүүлсэн цэцэрлэгүүдэд сургалт, мэдээлэл, зөвлөмж хийсэн.



2. Дархан-Уул аймгийн 21-р цэцэрлэгийн хүсэлт албан бичгийн дагуу Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглэх талаар мэдээлэл зөвлөмжийг 2019 оны 2-р сард цэцэрлэгийн удирдлага багш нарт хийсэн.

3. Дархан-Уул аймгийн бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, арга зүйч нарт Дархан-Уул аймгийн Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлтэй хамтран Эрчим хүчний хэмнэлтийн тухай ойлголт, хууль эрх зүйн орчин, эрчим хүч хэмнэх боломж, арга хэрэгслүүдийн талаар мэдээлэл зөвлөмж хийв.

4. Хүлэмжийн хий, Хас банкны Хүлэмжийн хий бууруулах зээлийн хөтөлбөр гэх мэт сургалт семинараас өгсөн мэдээлэлийг компанийн ажилтнууд болон иргэдэд мэдээлж ажилласан.



6. Ажилтнуудын бүтээлч сэтгэлгээ, шинэ санаачлагыг дэмжин Эрчим хүчийг хэмнэх үйл ажиллагаанд оролцох оролцоог идэвхижүүлэх зорилгоор компанийн ажилтнуудын дунд “Эрчим хүч хэмнэлт”-ийн зөвлөмж, Эссе бичлэгийн уралдаан 2019 оны 08-р сарын 01-нээс 2019 оны 09-р сарын 01-ний хооронд зарлаж 6 бүтээлийг шалгаруулж сарын үр дүнг 50 хувиар олгож урамшуулсан.

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ ШАЛТГААН

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

2019 он

ЭРЧИМ ХҮЧНИЙГ ХЭРХЭН ХЭМНЭХ ВЭ

ҮР АШИГТҮЙ ХЭРЭЛЭГТ БАГАСГА

ХЭМНЭЛТЭЙ ГЭРЭЛТҮҮЛЭГ АШИЛГА

Төрөл	Улаасаа 4x 6001	LED 4x 150x
Төсөрөг унаа	21 кВт/цаг	84 кВт/цаг
1 өрөөн байр	32900 тг/цаг	5100 тг/цаг
4 ширээт газар	131600 тг/цаг	20400 тг/цаг

Эрчим хүч хэмнэх өнөр оройн гэрэл


Улаагаар ажлын өдөр хийж байгууллага

Өрөөн хэрэглээ 08.00-17.00 цаг / 222.00.00 цаг /

Оройн хэрэглээ 17.00-22.00 цаг / 222.00.00 цаг /

Аян өрх

Өрөөн хэрэглээ / 08.00-21.00 цаг / 21.00.00.00 цаг /



4. Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүч хэмнэлтийн газар, Дархан-Уул аймгийн Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс өгсөн чиглэл, мэргэшүүлэх сургалт, мэдээлэлд оролцож хамтран ажиллах чиглэлээр хийгдсэн ажил:



1. Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний хэмнэлтийн газраас компанийн үйлчлэх хүрээнд байрлах үүрэг хүлээсэн хэрэглэгчидтэй уулзах уулзалтыг 4-р сард манай компанитай хамтран зохион байгуулсан. Тус уулзалтыг Шарын гол сум, Сайхан сум, Дархан суманд үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн төлөөллүүдийг нэгтгэж уулзалт мэдээлэл зөвлөмж хийхэд хамтран ажилласан.



Мөн Үүрэг хүлээсэн хэрэглэгч байгууллагуудаар ЭХЗХорооны Эрчим Хүчний Хэмнэлтийн Газрын дарга, мэргэжилтэнгүүдийн хамт явж мэдээлэл зөвлөмж өгсөн. Үүнд Хөтөл Цемент шохой ХК, Шарын гол ХК, Дулаан шарын гол ХК, Дарханы Нэгдсэн эмнэлэг гэх мэт



2. Эрчим хүч хэмнэлтийн газраас зохион байгуулсан “Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн нэгдсэн зөвлөгөөн, өдөрлөгт оролцож иргэдэд компанийн үйл ажиллагаа, эрчим хүчний хэмнэлт үр ашгийн талаар мэдээлэл зөвлөмж, тараах материалаар үйлчилсэн.



3. Эрчим хүчний зохицуулах хорооны Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөлөөс зохион байгуулж буй сургалт, семинар мэдээлэлд хамрагдаж мэдээллийг компанийн ажилтнуудад хүргэж ажиллаж байна. Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах хорооноос зохион байгуулсан эрчим хүчний аудитын тайлан боловсруулах талаар хийсэн 3 өдрийн семинарт 2019 оны 1 сард оролцсон.



- Обзерб консултинг ЗҮБ-аас зохион байгуулсан Эрчим хүчний хэмнэлтийн талаар мэдлэг хуваалцах 1 өдрийн уулзалт семинарт 2019 оны 3 сард оролцож мэдээллийг компанийн нэгжүүдэд өргөтгөсөн шуурхайд мэдээлсэн.
- Байгаль орчин аялал жуулчлалын яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос зохион байгуулсан Хүлэмжийн хий бууруулж “Кредит олгох механизм”-ын талаар хийсэн уулзалт семинарт оролцсон.



- Мөн Эрчим хүчний Эдийн засгийн хүрээлэнгээс зохион байгуулсан Ухаалаг эрчим хүч үр ашиг гэсэн илтгэлийн уралдаанд илтгэл хүргүүлж, 2019 оны 9-р сарын 27-нд онол практик эрдэм шинжилгээний хуралд оролцсон.



- Компанид 2019 шинээр ажилд орсон ажилтнуудад Эрчим хүч хэмнэлтийн хууль, журам, эрчим хүч хэмнэх талаар зөвлөмж хичээл орсон.

Компанийн 2019 оны Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийсэн ажлын гүйцэтгэлийг товч дүгнэвэл Үүрэг хүлээсэн үүргийнхээ дагуу цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдлыг төлөвлөгөөнөөс 3,8 нэгжээр буюу 18,1 сая кВт цагаар, өмнөх оны гүйцэтгэлээс 3,0 нэгжээр буюу 9,2 сая кВт цагаар бууруулж эрчим хүч хэмнэгдсэнээр агаар цацагдах хүлэмжийн хийг 8431,1 тн-оор бууруулсан.

Компанийн үйл ажиллагааны дотоод хэрэгцээний Эрчим хүчийг 15,8 хувиар бууруулж 270,3 мян кВт цаг эрчим хүч хэмнэж ЦЭХ-ний хэрэглээний зардлыг 3,9 сая төгрөгөөр бууруулж хэмнэсэн байна.


Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журамд заасны дагуу Эрчим хүчийг хэмнэх чиглэлээр хийсэн ажлын төлөвлөгөө, тайлангуудыг боловсруулж ЭХЗХороо, Эрчим хүч хэмнэлтийн газар, Дархан-Уул аймгийн Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд цаг хугацаанд гаргаж хүргүүлсэн.

Мөн ЭХЗХороо, Эрчим хүч хэмнэлтийн газраас зохион байгуулсан ажил, сургалт сименарт тухай бүрт нь оролцож шаардлагатай мэдээллүүдээр компанийн ажилтан, хэрэглэгчиддээ мэдээлж ажилласан. Мэдээлэл зөвлөж хийснээр “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль” журам, Эрчим хүч хэмнэх ойлголт мэдээлэлтэй болж үйл ажиллагаандаа ашиглаж байгаа эерэг талууд харагдаж үр дүн гарч байна. Тухайлбал манай компани Эрчим хүчтэй холбогдолтой цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж авахад Эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай дэвшилттэйг харж авч ашигладаг болсон. Компанийн ажилчид үргүй зардал хэрэглээг багасгаж дотоод хэрэгцээ сүүлийн 2 жилд буурсан.

Гурав. Түгээх үйл ажиллагааны чиглэлээр

3.1. Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын ажил

2019 онд Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын 62 ажлыг 6,2 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 62 ажлыг 6,2 тэрбум төгрөгөөр хийж ажлын гүйцэтгэл 100%-тай байна.



Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын ажлаар 35/6кВ-ын Элсэнкарьер дэд станцын 35кВ-ын ил вакуум таслуур суурилуулж реле хамгаалалт шинэчлэх, 35кВ-ын 8 км агаарын шугам шинээр барих, 0,4кВ-ын 64,7км агаарын шугамыг төмөр бетон тулгуур, СИП дамжуулагч утсаар шинэчлэх, тасралт ихтэй алслагдсан 6(10)кВ-ын 22км агаарын шугамыг төмөр бетон тулгуураар шинэчлэх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 6/0,4кВ-ын 2 дэд станцыг иж бүрэн КТП болгон шинэчлэх, 35/6кВ-ын 2 трансформаторт их засвар хийх, 6/0,4кВ-ын 3 дэд станцын барилгын засвар хийх, ухаалаг тоолуурын АМІ системийг НЕС систем рүү шилжүүлэх, нөөц серверийн зохион байгуулалт, гадна талбай цутгах, конторын

барилгын засвар хийх, парк шинэчлэлтийн ажлаар уртын тэрэг, автобус, худалдан авах зэрэг ажлуудыг хийсэн.

Их засварын ажлаар: 110/10кВ-ын Ерөө дэд станцын яч№7 Хандгайт, 35/6кВ-ын Жаргалант дэд станц яч№9 Загдал, 110/35/10кВ-ын Борнуур дэд станцын яч№4 Эрдэнэтолгой, яч№10 Арангат 10кВ-ын нийт 22км агаарын шугам төмөр бетон тулгуураар шинэчилж 2ш таслуурын байгууламж суурилуулсан.



Төв аймаг Заамар сум Хайлааст баг 35кВ-ын Хайлаастын агаарын шугамын ачаалал хөнгөлөх, нэвтрүүлэх чадварыг сайжруулах зорилгоор 110/35/10кВ-ын Баясгалант дэд станцаас 35кВ-ын 8км Өгөөмөр агаарын шугам шинээр барьсан.



❖ Барилгын засварын ажлаар Төв конторын дээвэр засвар болон 2 давхрын барилгын засварын конторын гадна автомашины зогсоолын талбайг цутгах, Спорт заалны ялтсан бойлер угсарч сантехникийн системийг бүрэн сольсон.

35/10кВ-ын Шаамар, Цагаантолгой, Цагааннуур дэд станцуудын хүчний трансформаторуудад засвар хийсэн.

13 хороололд байрлалтай 6/0,4кВ-ын ТП-49, 50, 51 дэд станцын дээвэр засвар, гадна барилгын засвар хийгдсэн.

Сэлэнгэ аймгийн Хушаат, Жавхланта, Орхон, Дархан сумыг цахилгаан эрчим хүчээр хангадаг 35/6кВ-ын Элсэнкарьер дэд станцын ил хуваарилах байгууламжийг шинэчилж 35кВ-ын вакуум таслуур, микропроцессор реле хамгаалалт суурилуулж удирдлагын самбарыг сольсон.



Давхрын щит засварлах ажил хийсэн.



Бугант тосгон 3,5-р орон сууцны 0,4кВ-ын 400м кабель шугам шинээр татах ажил хийсэн.



ТЗБАХ-ын ажлаар:

Дархан-Уул аймагт 9.4км, Сэлэнгэ аймагт 52.9км, Төв аймагт 1.5км нийт 15 дэд станцын 63.8км 0.4кВ-ын агаарын шугамыг төмөр бетон тулгуур бүрээстэй дамжуулагчаар шинэчлэх, шинээр барих ажил хийсэн.

Д/д	Аймаг	Сум	Салбар	Дэд станцын нэр	Шугамын урт /км/
1	Дархан	Дархан	ДТТ	КТП-201	6
2	Дархан	Дархан	ДТТ	АТП-120	1.4
3	Дархан	Хонгор	ДТТ	АТП-196	2
4	Сэлэнгэ	Хүдэр	ДТТ	АТП-108	5
5	Сэлэнгэ	Ерөө	ДТТ	ТП-1	4
6	Сэлэнгэ	Ерөө	ДТТ	АТП-135	6.9
7	Сэлэнгэ	Ерөө	ДТТ	АТП-102	5.4
8	Сэлэнгэ	Ерөө	ДТТ	ТП-4	1.5
9	Сэлэнгэ	Ерөө	ДТТ	АТП-117	5.4
10	Сэлэнгэ	Ерөө	ДТТ	АТП-103	6.8
11	Сэлэнгэ	Сүхбаатар	Сүхбаатар	АТП-103	9
12	Сэлэнгэ	Алтанбулаг	Сүхбаатар	ХТП-11	4
13	Сэлэнгэ	Сайхан	Хөтөл	АТП-109	2.2
14	Төв	Заамар	Жаргалант	Туулын гүүр	1.5
15	Төв	Сүмбэр	Зүүнхараа	АТП-139	2.4
16	Төв	Сүмбэр	Зүүнхараа	АТП-114	1.2
Дүн					64.7

Хүдэр сум АТП-108 дэд станцын 0,4кВ-ын 5км агаарын шугам модон тулгуур СИП утсаар сольж тоолуур төвлөрүүлэх ажил хийсэн.



Баянгол сум 110/10кВ-ын Баруунхараа дэд станц яч№10-ын 10кВ-ын агаарын шугамын а№4-өөс яч№8-ын агаарын шугамын Шу.С-2 хүртэл төмөр бетон тулгуураар шинэчилж схем хуваасан.

Дархан сумын 6/0,4кВ-ын КТП-201 дэд станцын 6км агаарын шугамыг төмөр бетон тулгуураар шинэчилсэн.

Зулзага хэсэгт шинэ суурьшлын бүсэд 6кВ-ын 0,5км агаарын шугам 6/0,4кВ-ын 250кВА чадал дэд станц, 0,4кВ-ын 2км агаарын шугам шинээр барих, Дархан сумын 15-р багт АТП-156 дэд станцын трасс өөрчилж 1,5км 6кВ-ын агаарын шугам СИП утсаар шинээр барьсан.




Сэлэнгэ аймгийн Ерөө суманд Ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж АТП-101, 102, 103, 117, 135, ТП-4 дэд станцуудын 0,4кВ-ын ЦДАШ-ыг шинэчилсэн. Энэ ажлын хүрээнд 870ш төмөр бетон тулгуур босгож, 30000м СИП утас татаж, 620ш ухаалаг тоолуур суурилуулсан.




Хөрөнгө оруулалтын ажлаар:

Нөөц серверийн суурилуулах, серверийн өрөөнд утаа мэдрэгч, дохиолол суурилуулах, Firewall хамгаалалт, 4 салбарт цаг бүртгэлийн систем суурилуулах, Суурин компьютер 7ш, notebook 2ш, парк шинэчлэлтийн ажлаар автобус, уртын тэрэг, зэргийг худалдан авах ажил хийгдсэн.

Олон улсын стандартын шаардлага хангасан DLMS, COSEM, IEC62056, QGDW- 376 протоколуудыг дэмждэг, IEC61968 протокол хангасан 3-дагч програмуудтай шууд холбогдох, урьдчилсан төлбөрт системд шилжин ажиллах, ус, дулаан, хий гэх мэт бусад түгээлтийн системд ажиллах, системээс тоолуурын тарифын цаг тохируулах, концентраторын тохиргоо хийх, унтрааж асаах зэрэг давуу талуудтай систем ашиглалтанд оруулсан.




Тоолуурын хяналт удирдлагын систем AMI системийг шинэчилж HES системрүү шилжүүлсэн. Мэдээллийн сангийн ARCGIS программ худалдан авч бааз бүрдүүлснээр тооцоо судалгаа, төлөвлөгөө гаргахад хялбар болсон.



Жаргалант салбарын Өгөөмөр хэсэгт контор худалдан авсан.



Системийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Firewall хамгаалалт ажилчдын файл хадгалах сервер QNAP сервер худалдан авч зохион байгуулалт хийсэн




3.2 Урсгал засвар

2019 онд компанийн хэмжээнд урсгал засварын 337 ажлыг 1 268 445 405 төгрөгөөр хийхээр төлөвлөн ажиллаж байна. Жилийн гүйцэтгэлээр 337 ажлыг 100%, зардлаар 1 537 407 955 төгрөгөөр хийж гүйцэтгэл нь 121,2%-тай байна.

2019 оны урсгал засварын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгж тус бүрээр үзүүлбэл:


Д/д	Салбар, Төв, Албадын нэр	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт дүн	
1	Сүхбаатар	Төл	1			5	11	2	4			3		26	
		Гүйц	1			5	11	2	3			4		26	
2	Зүүнхараа	Төл	1		8	5	5	2	2					23	
		Гүйц	1		8	5	5	2				2		23	
3	Хөтөл	Төл	2		3	9	4	2		2		1		23	
		Гүйц	2		2	6	7	2				4		23	
4	Жаргалант	Төл	1			5	5	3	2	1				17	
		Гүйц	1			5	3	1	2	1		4		17	
5	ДТТөв	Төл	1		10	19	8	12	2	8	10	6		76	
		Гүйц	1		9	19	4	6	2	4	13	18		76	
6	ХҮТөв	Төл	12	9	8	8	4	6	3	3	1			54	
		Гүйц	12	9	8	7	4	4	5	4	1			54	
7	ЗТТАлба	Төл	1	2	9	9	6	5	6	3	1	1		43	
		Гүйц	1	2	9	9	6	5	6	3	1	1		43	
8	ХТЛАлба	Төл			4	5	5	5	4	4	6	6		39	
		Гүйц			4	5	5	5	4	4	6	6		39	
9	ШҮМАлба	Төл	1			1			1					3	
		Гүйц		1			1		1					3	
10	ТҮААААлба	Төл	7	10	5	9	2							33	
		Гүйц	5	10	5	7	6							33	
Бүгд		Төл	27	21	47	75	50	37	24	21	18	17	0	0	337
		Гүйц	24	22	45	68	52	27	23	16	21	39	0	0	337
<i>Жилийн байдлаар %</i>														100	



Урсгал засварын гүйцэтгэлийг урьд онуудтай харьцуулсан үзүүлэлт
/ажлын тоо/

Он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Төлөвлөгөө	554	846	644	761	609	430	449	355	358	337
Гүйцэтгэл	518	820	636	759	612	432	454	355	357	337


2019 оны урсгал засварын зардлыг өмнөх онуудтай харьцуулсан үзүүлэлт



Урсгал засвараар дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 35/6кВ-ын Алтанбулаг д/ст яч№3 Хөдөө агаарын шугамын улаан будагтай модон тулгуурыг модон тулгуураар сольсон.
- 35/6кВ-ын Алтанбулаг д/ст яч№2 Төв агаарын шугамд төмөр бетон тулгуураар 8 анкер, 14 дундын тулгуур сольсон.
- 6(10)кВ-ын 30 дэд станцад 0.4кВ щитэнд ОПС суурилуулж холбосон.
- 6кВ-ын Зүүнхараа РП-1 ХХБ яч№2 Цагаан худаг агаарын шугамд төмөр бетон тулгуураар 6 анкер, 10кВ-ын СИП-50 утас 6000м татсан.
- 110/35/6кВ-ын Зүүнхараа дэд станцын яч№26 САА агаарын шугамд 12ш төмөр бетон тулгуур босгосон.
- 35/10кВ-ын Жаргалант дэд станцын яч№2, 4 10кВ-ын агаарын шугамд 24 төмөр бетон тулгуур босгож, 10кВ-ын СИП-50 утас 5800м татсан.
- 35кВ-ын Өгөөмөр агаарын шугамын С-24 модон порталийг 18м урттай стандарт тулгуур ашиглаж төмөр бетон портал угсарсан.
- 35/10кВ-ын Цагаантолгой дэд станцын яч№10 10кВ-ын агаарын шугамд төмөр бетон тулгуураар 18 дундын тулгуур 3 анкер босгосон.
- 6(10)/0.4кВ-ын дэд станцын 0.4кВ щитийг шинээр щит суурилуулж монтажилж угсарсан.

Урсгал засварын ажлын гүйцэтгэл




3.3 Эргүүл үзлэг

2019 онд нийт 8806 цэгт ээлжит эргүүл үзлэг хийхээр төлөвлөсөн. 2019 оны жилийн гүйцэтгэлээр 8806 үзлэгийг хуваарийн дагуу 100% хийж гүйцэтгэсэн

2019 оны жилийн эргүүл үзлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэл /хүснэгтээр/

Д/д	Салбар хэсгийн нэр	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	
			Биет	Хувь
1	ДарханТТөв	2252	2252	100%
2	Дархан ХҮТ	1718	1718	100%
3	Сүхбаатар	1236	1236	100%
4	Зүүнхараа	700	700	100%
5	Хөтөл	1092	1092	100%
6	Жаргалант	740	740	100%
7	ЗТТАлба	576	576	100%
8	ХТЛАлба	362	362	100%
9	МТААлба	130	130	100%
10	Нийт	8806	8806	100%

2019 онд хийгдсэн эргүүл үзлэгийн гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад



Өвлийн их ачааллын үеэр цаг агаар хүйтэрч байгаатай холбогдуулан шугам тоноглолын найдвартай ажиллагааг хангахын тулд агаарын шугамд ээлжит бус үзлэг хийх ажлыг нэгдүгээр сард зохион байгуулсан.

Сар шинийн баярын өмнө нэгж тус бүр ээлжит ба ээлжит бус эргүүл үзлэг хийх төлөвлөгөөг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс гарган үзлэг зохион байгуулж илэрсэн гэмтэл зөрчлийг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан устгах ажлыг зохион байгуулж ажилласан.

**ДСЦТС ХК-ИЙН БАЯРЫН ӨМНӨХ ЭРГҮҮЛ ҮЗЛЭГ БОЛОН ҮЗЛЭГЭЭР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ
УСТГАСАН БАЙДАЛ**

Д/д	Салбар, төв, албадын нэрс	Шугам тоноглолд үзлэг хийсэн цэгийн тоо	Үзлэгээр илэрсэн зөрчлийн тоо	Зөрчил устгаж хэвийн болгосон тоо	Зөрчил устгасан байдал хувиар
1	Сүхбаатар салбар	235	44	44	100%
2	Зүүнхараа салбар	210	9	9	100%
3	Жаргалант салбар	136	8	8	100%
4	Хөтөл салбар	79	35	28	80%
6	Дархан хэрэглэгчдэд үйлчлэх төв	745	82	82	100%
7	Дархан түгээх төв	491	20	20	100%
8	Засвар туршилт тохируулгын алба	60	6	6	100%
	Нийт дүн	1956	204	197	96.5%

Компанийн хэмжээнд 1956 цэгт ээлжит ба ээлжит бус эргүүл үзлэгийг зохион байгуулж 204 гэмтэл илрүүлж, 204 зөрчил буюу 100%-ийн гэмтэл зөрчлийг устгаж ажилласан.

3.4 Бэлэн байдал шалгасан талаар

Компанийн тусгай төхөөрөмжтэй болон бусад машин механизмын бэлэн байдлыг шалгах ажлыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж илэрсэн дутагдлын талаар Тээвэр үйлчилгээ аж ахуйн албаны дарга, механик, жолооч нарт мэдэгдэн шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

Санхүү эдийн засгийн хэлтэстэй хамтран аваарийн нөөц материал болон складанд байгаа сэлбэг материалд үзлэг хийж шаардлагатай материал сэлбэгийг бүрдүүлж ажилласан.



3.5 Аянгын улирлын бэлтгэл ажлын талаар


2019 онд аянгын улирлын бэлтгэл ажлаар графикийн дагуу 35кВ-н 29 дэд станцын 111 цэнэг шавхагчид өндөр хүчдэлийн туршилт, хэмжилт хийсэн. Үүнээс 35/0,4кВ-н Галагтай дэд станцын А фазын цэнэг шавхагч, А В С фазын цэнэг шавхагчын тоолуур шаардлага хангахгүй байсан тул шинээр сольж тавьсан. Мөн 35/10кВ Жаргалант дэд станцад 3 ш цэнэг шавхагч, 35/10кВ Угтаал дэд станцын А, В фазын цэнэг шавхагч, 35/10кВ Майхант дэд станцад 3ш цэнэг шавхагч солих шаардлагатайг сольсон.

ЦДҮС ТӨХК-ийн 110кВ-ын дэд станцуудаас гарсан 50ш гаргалгааны Анкерт газардуулгын хүрээний эсэргүүцэл хэмжив. Үүнээс 19-н цэгт газардуулга сэргээх шаардлагатайг сэргээсэн.

3.6 Тасралт

2019 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд 386 удаа тасралт гарсан бол тасралтын дундаж хугацаа 4.02 цаг, ДТЭХ 136 086 кВт*цаг байгаа нь 2018 оны мөн үетэй харьцуулахад тасралт 66 тасралт буюу 14.7%, дундаж хугацаа 1.74 цаг буюу 30.3%, ДТЭХ 8798 кВт*цаг буюу 6.1%-иар тус тус буурсан байна.

Тасралтыг өмнөх онтой харьцуулахад:



2012-2019 оны нийт тасралтын дундаж хугацааг графикаар үзүүлэв





2015-2019 оны дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчийг графикаар үзүүлэв




Гэмтэл тусгаарлаж 98 удаа, гадны байгууллагын буруугаас 43 удаа, ашиглалтын ажиллагаанаас 160 удаа тасарсан бол цаг агаарын байдлаас 85 удаагийн тасралт гарсан байна.

Тасралтыг ангилан харуулбал:




Нэгжүүдийн тасралтыг өмнөх онуудын мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад:



Тасралтыг төрлөөр нь ангилж үзэхэд 187 буюу 48.4% нь тодорхойгүй шалтгаанаар шалтгаалан тасарсан.

2016, 2017, 2018, 2019 онуудын 35, 6, 10кВ-ын сүлжээний тасралтыг доорхи графикаар үзүүлэв:



35, 10, 6 кВ-ын сүлжээний их тасралттай шугамуудыг тус бүрээр нь хүснэгтээр харуулбал:

Д/д	Диспетчерийн нэр хаяг	Ячейкийн дугаар	Хүчдлийн түвшин	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
35кВ-ын сүлжээний хамгийн их тасарсан шугам											
1	35кВ-ын РГ-11	яч№5	35	12	13	4	11	3	25	23	11
2	35/6кВ-ын Элсэнкарьер д/ст	Энхтал АШ	35					5	9	7	9
3	110/35/10кВ-ын Орхон д/ст	Орхонтуул АШ	35	4	5	11	6	8	6	6	8
4	110/6кВ-ын Толгойт д/ст	яч№2	35	16	17	7	10	8	2	7	7
5	35/10кВ-ын Угтаал д/ст	Заамар АШ	35							4	7
6	35кВ-ын РГ-11	яч№6	35						20	10	5
7	35/6кВ-ын Элсэнкарьер д/ст	Жимс АШ	35			3	11	5	4	3	5
8	110/35/6кВ-ын Зүүнхараа д/ст	Түнхэл АШ	35					8	1	4	3
9	110/35/10кВ-ын Борнуур д/ст	Жаргалант АШ	35								3
10	35/10кВ-ын Орхонтуул д/ст	Майхант АШ	35								3
11	35/10кВ-ын Шаамар дэд станц	Зүүнбүрэн АШ	35	6	6	10	4	5	4	2	2
12	35/10кВ-ын Зүүнбүрэн д/ст	Цагааннуур АШ	35								2
13	110/35/6кВ-ын Сүхбаатар д/ст	Шаамар АШ	35								2
14	35/6кВ-ын Заамар д/ст	Ар-Урт АШ	35								2
15	35/6кВ-ын Заамар д/ст	35кВ-ын В.Т	35								2
16	35/10кВ-ын Жаргалант д/ст	Угтаал АШ	35							4	1
6, 10кВ-ын сүлжээний хамгийн их тасарсан шугам											
17	35/6кВ-ын Хонгор д/ст	яч№8	6	4	7	8	8	9	7	7	13
18	110/35/10кВ-ын Борнуур д/ст	яч№10	10							8	12
19	110/10кВ-ын Баруунхараа д/ст	яч№8	10	6	8	11	13	7	10	17	12
20	110/35/10кВ-ын Борнуур д/ст	яч№8	10	6	8	8	14	11	3	11	9
21	6кВ-ын РГ-10	яч№10	6							3	9
22	6кВ-ын РГ-10	яч№9	6							9	8
23	110/35/6кВ-ын Зүүнхараа д/ст	яч№26	6								8
24	110/6кВ-ын Бурхант д/ст	яч№10	6	34	12	20	19	10	12	9	8
25	110/35/10кВ-ын Орхон д/ст	яч№2	10							4	7
26	110/35/6кВ-ын Сүхбаатар д/ст	яч№8	6							5	7
27	110/6кВ-ын Бугант д/ст	яч№14	6							7	6
28	35/6кВ-ын Хонгор д/ст	яч№4	6							7	6
29	110/6кВ-ын Давхар д/ст	яч№19	6								6
30	110/6кВ-ын Давхар д/ст	яч№8	6								5
31	35/10кВ-ын Жимс д/ст	яч№8	10	12	8	14	8	7	7	4	5
32	6кВ-ын РГ-8 ХХБ	яч№4	6								5
33	110/35/10кВ-ын Орхон д/ст	яч№12	10	10	5	3	8	7	10	6	5
34	35/10кВ-ын Цагааннуур д/ст	яч№5	10	6	6	16	7	5	2	8	5
35	35/10кВ-ын Жаргалант д/ст	яч№5	10							5	5
36	35/10кВ-ын Жаргалант д/ст	яч№9	10							14	4
3	Хөтөл			332	1541
4	Жаргалант	85	667	536	3090
5	ДХҮТөв			821	3323
6	ДТТөв			244	1007
7	ЗТТА			247	521
8	ШҮМА			238	959
9	ХТЛА			31	102
Дүн		1014	5020	4863	22545



ISO45001:2018 ХЭМАБ-ын стандартын 6 дугаар бүлэг шаардлага, Монгол Улсын Засгийн газрын а/295 дугаар тушаалын хүрээнд Компанид захиалга наряд шийдвэрээр хийгдэж буй ажил болгонд ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийн ажиллаж байна.






4.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хяналт

ХАБЭА-н гурван шатны хяналтыг үзлэгийг зохион байгуулан ажилласан. 2019 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд хийгдэх 7184 захиалгат ажлаас 7128 ажлын захиалгыг хянаж батлуулан, 56 захиалга батлагдаагүй хойшлогдсон байна. Үүнээс нарыдаар 2616, шийдвэрээр 3582 ажил хийгдсэн. Техникийн арга хэмжээний зөрчилтэй, бүрэн авагдаагүй дутуу, зохион байгуулалтын арга хэмжээ дутуу, аюулгүй ажиллагаа хариуцагч нарыг буруу томилсон, бригадын бүрэлдэхүүн хангалтгүй буюу хийгдэх ажил нь тодорхойгүй, наряд олгогч нь тухайн ажилд наряд олгох эрхгүй ажилтан наряд олгосон зөрчилтэй 147 нарядыг зөрчлийг арилгуулан нарядыг дахин олгуулж ажилд оруулсан байна.

Нарыдаар хийгдэх ажлын нарядыг ажил эхлэхийн өмнөх өдөр 16 цагаас өмнө салбаруудаас диспетчерийн емейл хаягаар төвийн хэсгүүдээс эх хувиар нь хүлээн авч нарядын зохион байгуулалтын арга хэмжээ, техникийн арга хэмжээг хянаж зөрчил гарсан нарядыг буцаан дахин наряд олгуулж хяналт тавьж ажиллалаа.

Наряд шийдвэрээр хийгдсэн ажлуудыг салбар хэсэг нэгжээр харуулбал:



ХАБЭА-н анхан шатны болон II шатны үзлэгийн Салбар, төв, алба нь журмын дагуу зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байдлыг дүгнэж үзэхэд:

№	Салбар, төв, алба төвийн нэр	Анхан шатны үзлэг			II шатны үзлэг		
		Үзлэгийн тоо	Үзлэгээр илэрсэн зөрчил	Арилгасан зөрчлийн тоо	Үзлэгийн тоо	Үзлэгээр илэрсэн зөрчил	Арилгасан зөрчлийн тоо
1	Сүхбаатар	858	4	0	2	3	3
2	Жаргалант	838	14	7	58	21	15
3	Зүүнхараа	1649	17	15	46	28	28
4	Хөтөл	489	160	144	66	209	122
5	ДТТ	665	64	46	23	19	15
6	ДХҮТ	847	1	0	9	13	13
7	ЗТТА	123	7	7	13	0	0
8	ШУМА	716	10	10	61	1	1
9	ХТЛА	42	7	6	10	9	10
	Нийт	6227	284	235	288	303	207

ХАБЭА-н анхан шатны үзлэгээр илэрсэн зөрчил нь ажилтнуудын хамгаалах хэрэгсэл актлагдсан дахин олгогдоогүй байгаа агаарын шугамуудад хийсэн үзлэгийн зөрчлүүд илэрсэнийг урсгал засвараар арилгахаар төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна.


4.3. ХАБЭА-н дасгал сургууль явуулсан талаар

Компанийн хэмжээнд явагддаг дасгал сургуулиудыг оны эхэнд батлагдсан төлөвлөгөөний дагуу ХАБЭА дасгал сургууль явуулах журмын дагуу хугацаандаа хийгдэж 2019 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт 64230 ажилтан хамрагдсан байна.

2018 оны мэдээтэй харьцуулсан дүнг хүснэгтээр харуулбал:

№	Утга	2018 он	2019 он
1	Давтан зааварчилгаа	3182	2971
2	Ээлжит бус давтан зааварчилгаа	2853	2343
3	Өдөр тутмын давтан зааварчилгаа	32329	30216
4	Аваар эсэргүүцэх дасгал	3192	3071
5	Осол эсэргүүцэх дасгал	3236	3078
6	Гал эсэргүүцэх дасгал	1196	1561
7	Тухайлсан зааварчилгаа	17677	20888
8	Анхан шатны зааварчилгаа	72	102
	Нийт дүн	63737	64230

2018 оны мэдээтэй харьцуулсан дүнг графикаар харуулбал:




ХАБЭА өдөрлөг явуулах төлөвлөгөөний дагуу сар бүр Зүүнхараа, Хөтөл, Сүхбаатар, Жаргалант салбар нь өдөрлөгийг журамд заасан хугацаандаа зохион байгуулж байгаа боловч бусад нэгж хэсгүүдийн ар дааж үлдсэн ажилтнууд журамд заасан хугацаанд тогтмол хамрагдах боломжгүй байгаа тул тус нэгж хэсгийн ажилчдад дахин өдөрлөг зохион байгуулах ажил хийгдэж байна.

нэгж хэсгийн ажилчдад дахин өдөрлөг зохион байгуулах ажил хийгдэж байна.

Компанийн хэмжээнд салбар алба төв ажилтнуудаа зааварчилгаанд хамруулсан байдлыг дүгнэж үзэхэд:

№	Салбар, алба, төвийн нэр	Анхан шатны зааварчил гaa авсан хүний тоо	Өдөр тутмын зааварчилгаа авсан хүний тоо	Сарын давтан зааварчилгаа авсан хүний тоо	Ээлжит бус зааварчил гaa авсан хүний тоо	Тухайлсан зааварчилгаа авсан хүний тоо	Нийт тоо
1	Сүхбаатар	6	5310	380	223	2383	8302
2	Жаргалант	18	1807	322	277	2299	4723
3	Зүүнхараа	18	3729	345	430	3418	7940
4	Хөтөл	14	1987	295	219	1538	4053
5	ДТТ	8	3270	372	54	2616	6320
6	ДХҮТ	6	8115	609	241	2368	11339
7	ЗТТА	19	388	198	78	1504	2187
8	ШУМА	5	2061	151	415	1757	4389
9	ХТЛА	5	1240	94	65	358	1762
Нийт дүн		99	27907	2766	2002	18241	51015

Нэгж хэсгүүдийн ажилтнуудаа зааварчилгаанд хамруулсан байдлыг графикаар харуулбал:



Тухайлсан зааварчилгааг шат дараалсан хэлбэрээр Аюулгүй ажилгааны дүрэм, техник ашиглалтын дүрэм болон холбогдох аюулгүй ажиллагааны заавруудын заалт бүрээс хийгдэх ажилтай нь холбогдуулан чанартай өгч байгааг шалгах зорилгоор мэйл хаягаар авч шалгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Компанийн хэмжээнд шинээр ажилд орсон болон үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирсэн суралцагч нарт Урьдчилсан зааварчилгаа 96 хүнд, гадны зочидод зочины зааварчилгааг 96 хүнд өгсөн байна.

4.4. Мэргэшлийн ээлжит шалгалтын талаар

2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу 01-р сарын 07-31-ыг дуустал мэргэжлийн ажилтнуудаас ээлжит шалгалтыг авч ажилласан.

Шалгалтын дүн					
№	Салбар нэгжийн нэр	Өгсөн	Ээлжит		Шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн Шалгалт өгөөгүй ажилтны тоо
			Тэнцсэн	Тэнцээгүй	
1	Сүхбаатар	51	51		
2	Жаргалант	32	32		
3	Зүүнхараа	41	40		1
4	Хөтөл	29	29		
5	ДТТ	40	40		
6	ХТЛА	10	10		
7	ДХҮТ	64	64		
8	ШУМА	15	15		
9	ЗТТА	21	21		
10	Хэлтсүүд	14	14		
	Нийт	328	328	0	1

Компанийн хэмжээнд ажлын байр өөрчлөгдсөн болон групп зэрэг нэмэх ажилтнуудад 3 өдрийн 24 цагийн батлагдсан хөтөлбөрөөр сургалт орж, 05-р сарын 21-24-ний өдрүүдэд шалгалт авсан ба нийт 34 ажилтан шалгалт өгсөнөөс 7 ажилтан тэнцсэн.

4.5. Аюул илрүүлэлт устгалтын талаар

2019 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд Аюулыг мэдээлэх хуудсаар 149 мэдээлэл ирснийг аюулын хэмжээгээр нь ангилж үзэхэд их аюултай ба ноцтой-105, дунд болон бага эрсдэлтэй-43 үл тохирол аюул мэдээлэх хуудсаар ирсэнээс их аюултай ба ноцтой-91, дунд болон бага эрсдэлтэй-35 үл тохирол устгасан байна.

Зөрчлийг арилгасан байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Зөрчлийн төрөл	2018		2019	
		Илэрсэн зөрчлийн тоо	Зөрчлийг арилгасан тоо	Илэрсэн зөрчлийн тоо	Зөрчлийг арилгасан тоо
1	Дэд станц, ХБ-н шал доош суусан, дээврээс ус гоожсон	10	2	8	6
2	Машин механизмын гэмтэл, зөрчил	2	2	0	0
3	Кабель шугам	12	5	10	10
4	Тоног төхөөрөмжийн ашиглалтын зөрчил	83	59	65	56
6	Шугамын трасс цэвэрлэх	5	3	5	5
7	Тулгуур хазайсан	21	11	23	19
8	ЦДАШ утас унжилттай	13	7	0	0
9	Ажлын байрны эмх цэгц	1	0	13	12
10	гадны байгууллагын зөрчил	9	4	14	7
11	диспетчерийн нэр хаяг сэргээх, цоож түгжээ хийх	22	14	11	11
Нийт дүн		178	107	149	126
Үл тохирлыг залруулсан байдал		60.1 %		84.5 %	

Дээрх хүснэгтээс зөрчлийг арилгасан байдлыг хувиар илэрхийлбэл 84,5 % гүйцэтгэлтэй байна.

Устаагүй нийт үл тохиролуудыг тоног төхөөрөмжийн хөрөнгийн эзэмшилээр нь ангилж үзвэл:

- Гадны байгууллагын шугам тоноглолд-7
 1. Гадны байгууллагын эзэмшлийн тоног төхөөрөмж-6
 2. Гадны байгууллагын эзэмшлийн тоног төхөөрөмжид манай байгууллагын шуурхай ажиллагааны ажилчид үйлчилдэг-1
- Компаний эзэмшлийн шугам тоноглолд-15
 1. Зүүнхараа салбар-1
 2. Хэмжүүр тоолуур лабораторын алба-5
 3. Дархан түгээх төв-6
 4. Хөтөл салбар-1
 5. Сүхбаатар салбар-1
 6. Жаргалант салбар-1

Зөрчлийг арилгасан байдлыг графикаар харуулбал:



4.6. Технологийн зөрчлийн талаар

2019 онд компанийн шугам тоноглолд гадны байгууллага хэрэглэгчийн буруутай үйлдлийн улмаас 22 удаагийн технологийн зөрчил гарч 51549334.33 төгрөгийн хохирол учирсаныг буруутай этгээдээр төлүүлэн ажиллаж байна.

№	Зөрчлийн ангилал	Технологийн зөрчлийн тоо	Нийт хохирол /мян.төг/	Төлөгдсөн дүн /мян.төг/
1	Гадны хүний буруугаас	22	51549334.33	15339209.23
Дүн		22	51549334.33	15339209.23

Технологийн зөрчлийг салбар, нэгжээр нь харуулбал:

№	Салбар нэгж	Технологийн зөрчлийн тоо	Нийт хохирол /төг/	Төлөгдсөн дүн /төг/
1	Сүхбаатар салбар	6	11373799.7	8602372.7
2	Хөтөл	2	1429616.45	1429616.45
3	Дархан түгээх төв	5	6358496.68	2505002.88
4	ЗТТАлба	7	30867024.17	2077687.2
5	Шарын Гол	1	724530	724530
6	Зүүнхараа	1	795867.327	0
Дүн		22	51549334.33	15339209.23

Гал гарсан, агаарын шугамын нойл тасарсан гэх мэт зөрчлүүдэд комисс тухай бүрт ажиллаж, технологийн зөрчил бүртгэх хуудас 45ш бичигдэж хэрэглэгчээр гарын үсэг зуруулж ажилласан байна.

4.7. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалтыг сайжруулах талаар Компанийн хэмжээнд өвлийн ажлын тусгай хувцас-гутал-, зуны ажлын тусгай хувцас, гутал, хортой нөхцөлд ажилладаг ажилтнуудад "Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох журам"-н дагуу бүтээгдэхүүнийг олгож ажилласан.

2019 оны жилийн эцсийн байдлаар туршилтанд орсон хамгаалах хэрэгслийг хүснэгтээр харуулбал:


Д/д	Салбар хэсэг	Штанг /ШО-10.15.35/			Зөөврийн газардуулга /ЗПЛ.ЗПП-10.15.35/			Газардуулгын штанг /ШЗП-10.35/	
		10 кВ	15 кВ	35 кВ	10 кВ	15 кВ	35 кВ	10 кВ	35 кВ
1	ЗТТА	11				8			
2	ДТТ	13			11	4	3		1
3	ШУМА			1		2			
4	ХТЛА								
5	ХҮТ	17				16			
6	Сүхбаатар	4	1		5	6			
7	Жаргалант	3		4		2	1		
8	Хөтөл	3	1	8	6	2	5		
9	Зүүнхараа	20		10	15				
10	ТБТХэлтэс								
12	Нийт	71	2	23	37	40	9		1

Д/д	Салбар хэсэг	Дөрөө	Бүс	Бээлий	Боть	УВН-80	Резинин дэвсгэр	Фаз увн	Монтонын багаж	Нийт	Акт	
											Х/Хэрэгсэл	Дөрөөний сур
1	ЗТТА	38	9	22	10	48	189	27	13	375	10	
2	ДТТ	59	22	38	12	10			25	198	30	1
3	ШУМА	25	13	14		10		1	27	93	3	
4	ХТЛА	7	4	10		1			60	82	2	
5	ХҮТ	110	29	49	19		16			256	7	
6	Сүхбаатар	73	29	33	8	21	11	5	48	244	6	
7	Жаргалант	43	15	47	8	21	20		19	183	1	
8	Хөтөл	39	19	21		31	3	7	14	159	14	
9	Зүүнхараа	92	39	56	22	26	35	5	67	387	22	1
10	ТБТХэлтэс			3						3		
12	Нийт	487	150	293	79	91	168	45	273	1980	95	2

2019 оны жилийн эцсийн байдлаар хамгаалах хэрэгсэл, галын булан, плакат олгосон байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Салбар хэсгийн нэр	Хамгаалах хэрэгсэл	Галын булан	Плакат	Нийт дүн
1	ДТТөв	214	55	445	714
2	ДХҮТөв	362		537	899
3	СЭЗХэлтэс		22		22
4	ТБТХэлтэс	1	2		3
5	МТААлба		1		1
6	ЗТТАлба	410	1		411
7	ХТЛА	16			16
8	ШҮМАлба	26			26
9	ТҮАААлба		9		9
10	Сүхбаатар салбар	130	3	68	201
11	Хөтөл салбар	113	13	128	254
12	Жаргалант салбар	119	152	328	599
13	Зүүнхараа салбар	320	8	283	611
Нийт дүн		1711	266	1,789	3,766

Хамгаалах хэрэгсэл, галын булан, аюулгүй ажиллагааны плакат олголтыг графикаар харуулбал:



4.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардлын талаар

2019 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд 255 017 000 төгрөгийг зарцуулсан байна. Зардлыг задалж харуулбал:

Хамгаалах хэрэгсэл- 117 513 000 төгрөг


Аюулгүй ажиллагааны плакат -18 232 000 төгрөг

Галын булангийн хэрэгсэлд- 2 900 000 төгрөг

Ажлын тусгай хувцас, хэрэгсэлд- 107 417 000 төгрөг

Хоргүйжүүлэх сүү, эмийн сан болон бусад зүйлд- 8 955 000 төгрөг байна.

ХАБЭА-н зардлын задаргааг графикаар харуулбал:



Хамгаалах хэрэгсэл, галын булангийн багаж хэрэгсэл олголтыг салбар, нэгжээр харуулбал:

№	Салбар хэсгийн нэр	Хамгаалах хэрэгсэл		Галын булан		Плакат		Нийт дүн	
		Тоо ширхэг	Үнэ /мян.төг/	Тоо ширхэг	Үнэ /мян.төг/	Тоо ширхэг	Үнэ /мян.төг/	Тоо ширхэг	Үнэ /мян.төг/
1	ДТТөв	214	17,453.2	55	1088.0	445	2725.7	714	21266.8
2	ДХҮТөв	362	32,114.6			537	1692.2	899	33806.7
4	СЭЗХэлтэс			22	222.5			22	222.5
7	ТБТХэлтэс	1	76.0	2	70.0			3	146.0
8	МТААлба			1	122.7			1	122.7
9	ЗТТАлба	410	19,131.4	1	9.0			411	19140.4
10	ХТЛА	16	2,044.1					16	2044.1
11	ШҮМАлба	26	2,677.9					26	2677.9
12	ТҮАААлба			9	315.0			9	315.0
13	Сүхбаатар салбар	130	12.0	3	105.0	68	335.0	201	452.0
14	Хөтөл салбар	113	9,827.6	13	314.3	128	372.0	254	10513.8
15	Жаргалант салбар	119	7,215.7	152	374.0	328	2167.0	599	9756.7
16	Зүүнхараа салбар	320	26,960.2	8	280.0	283	10940.0	611	38180.2
Нийт дүн		1711	117,513	266	2,900	1,789	18,232	3,766	138,645

4.9. Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

Гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 329 удаагийн үзлэгийг 826 нэгжийг хамруулан хийсэн ба 122 зөрчил илрүүлж 117 зөрчлийг устгасан байна. Мөн галын булангийн багаж хэрэгсэлд галын хор-44 ширхэг, элсний хувин, троссон цохиур, сүх, хүрз, жоотуу, галын дэгээ зэрэг нийт 60 ширхэг галын багаж хэрэгсэл олгосон байна.

Монгол улсын Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын дагуу Гамшгийн үед зарлан мэдээллийн дохиогоор нэгэн зэрэг ажиллах сургалтыг жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагт улс орон даяар гамшиг, ослын дуут дохиог ажиллуулж, гамшгийн үеийн бэлтгэл сургуулилт хийдэг. Энэ жил уг өдөр 21-нд тохиож байгаа бөгөөд 16:00 цагт улс даяар нэгэн зэрэг зохион явууллаа. Улс орон даяар зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, түүнд хамрагдаж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог дээшлүүлэх зорилгоор аймгийн Онцгой байдлын газраас энэ дадлага, сургуулийг ес дэх жилдээ зохион байгуулж байгаа юм. Газар хөдлөлтийн гамшгийн аюул тулгарсан үед ААНБ-ын бэлэн байдлыг хангуулах, Дархан-Уул аймагт суурилуулсан төвлөрсөн зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдал үйлчлэх хүрээг шалгах, иргэдийг гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллуулж сургах ач холбогдолтой тус үйл ажиллагаанд ДСЦТС ХК-ийн хамт олон 100 хувийн ирцтэй оролцож бэлэн байдлаа шалгуулсан.



4.10 Хяналт шалгалт

A/ Мэргэжлийн хяналтын газрын шалгалт

Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч нар 2 чиглэлээр 2 хяналтын хуудсаар шалгасан.

Сэлэнгэ аймгийн МХГ-ын Улсын шалгагч нь Цагаануур сум, Мандал суманд хийгдсэн хяналтын хуудсыг одоогийн байдлаар ирүүлээгүй байна. МХГ-ын улсын байцаагч Ч.Алтангэрэл нь Сүхбаатар салбарын Түшиг хэсэгт болон Зүүнхараа салбарт Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага ирүүлсэн бөгөөд зөрчлийг арилгаж тайланг хүргүүлсэн. 2019 оны 04 сарын 03 ны өдөр МХГ-ын Харилцаа холбооны улсын байцаагч Д.Энхтөр мэдээлэл холбоо, сүлжээний 20 төрлийн хяналт шалгалтын хуудсаар шалгаж 19 шаардлагад тэнцэж, 1 шаардлага хангаагүй, эрсдэл үүсэх магадлалын хувь 9,7%, эрсдэл үүсгэх магадлал бага гэсэн үнэлгээ авсан. Харилцааны холбооны радио долгион ашиглаж байгаа байгууллага радио долгионы давтамж, чадлын хэмжих багажтай байх гэсэн шаардлага тавьсан.

д/д	Хяналтын чиглэл	Шалгалт хийсэн огноо	Хууль сахин мөрдөлтийн хувь	Эрсдэл үүсэх магадлалын хувь	Эрсдэл үүсэх магадлал
1	Цахилгаан эрчим хүч түгээх үйл ажиллагааг шалгах хяналт /Сэлэнгэ аймаг Түшиг сум/	2019.03.04	80.0%	31.0%	дунд
2	Радио долгион ашиглагч этгээдийн үйл ажиллагааг шалгах хяналт /Дархан-Уул аймаг Дархан сум /	2019.04.11	98.0%	9.7%	бага
2	Дүн		89,0	20,35	бага



МХГ-ын шалгалтаар хууль сахин мөрдөлт 89,0%-тай, эрсдэл үүсэх магадлал түгээх үйл ажиллагаанд дунд эрсдэлтэй, радио долгион ашиглах үйл ажиллагаанд бага эрсдэлтэй дүгнэгдлээ.

Цахилгаан эрчим хүч түгээх үйл ажиллагааг шалгахад хамгийн их эрсдэлтэй үнэлэгдэж буй эрчим хүчний хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажлын хүрээнд нэгдсэн судалгааг гаргах хүснэгт боловсруулан салбар нэгжүүдэд өгч судалгааг нарийвчлан гаргасан. Судалгааг үндэслэн Засаг даргын тамгын газар, Газар хот төлөвлөлтийн газар зэрэг байгууллагуудтай хамтарч зөрчлийг үе шаттайгаар арилгах ажлууд хийгдэж байна.

Сэлэнгэ аймгийн Улсын байцаагч Т.Мөнхтүвшин нь Мандал суманд үйл ажиллагаа явуулж байсан техник ашиглалтын шаардлага хангахгүй Хайрханбуянт ХХК хэрэглэгчийг цахилгаан дамжуулах агаарын шугамыг өндөрлөх цахилгаан хангамжийг зөрчлийг арилгах шаардлага тавьж түр хязгаарласан. МХГ-ын улсын байцаагч Ч.Алтангэрэл нь Сүхбаатар салбарын Түшиг хэсэгт болон Зүүнхараа салбарт МУ-ын Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлагын дагуу зөрчлийг арилгаж тайланг бичиж хугацаанд нь хүргүүлж, Улсын байцаагч нарын өгсөн зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгахаар төлөвлөгөөг боловсруулан нэгжүүдэд хүргүүлж зөрчлүүдийг арилгаж ажилласан.


Б/ Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2019 онд Захиргаа удирдлагын хэлтэс, Тээвэр үйлчилгээ аж ахуйн алба, Дархан түгээх төв, Шуурхай үйлчилгээ мэдээллийн алба, Дархан хэрэглэгчдэд үйлчлэх төв, Мэдээлэл технологи автоматикийн алба, Засвар туршилт тохируулгын алба, Хөтөл, Зүүнхараа, Сүхбаатар салбар, Хэмжүүр тоолуур лабораторын алба, 11 нэгжид хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2019 оны Төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг илрүүлж эрсдэлийг үнэлж ажилласан.




4.11 Хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажил

“Эрчим хүчний тухай хууль”-ийн 33-р зүйл, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийг үндэслэн ДСЦТС ХК-ийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэрийн хамгаалалтын зурваст байгаа хэрэглэгч 2019 оны эхэнд ЦДАШ-ын хамгаалалтын бүсэд 705, дэд станцын хамгаалалтын бүсэд 13, КШ-ын хамгаалалтын бүсэд 19, нийт 737 цэг байснаас 10 цэгийн хашааг татуулж, хуучин шугам буулгаж 7 цэг, трасс өөрчилж 54 цэг нийт 71 цэгийг хамгаалалтын зурвасаас чөлөөллөө. Мөн эрсдэл бууруулах чиглэлээр 37 цэгт СИП дамжуулагч татсан.





Хэсэг нэгж	Хамгаалалтын зурваст байсан				Хамгаалалтын зурвасаас хасагдсан				Хувиар
	АШ	Дэд станц	КШ	нийт	АШ	Дэд станц	КШ	нийт	
Сүхбаатар	211	0	0	211	19	0	0	19	9.0%
Хөтөл	25	1	8	34	12	0	0	12	35.3%
Зүүнхараа	90	1	11	102	13	0	2	15	14.7%
Жаргалант	104	8	0	112	7	0	0	7	6.3%
ДТТ	275	3	0	278	18	0	0	18	6.5%
Нийт	705	13	19	737	69	0	2	71	9.6%



4.12. Өргөдөл гомдол

2019 онд сонирхогч талуудаас 2209 өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.




Төрөл	Ангилал	Утга	Нийт тоо	
			2018 он	2019 он
Хүсэлт	Техник үйлчилгээ	Хүчдэлд холбуулах, цахилгаан хангамжаа түр хугацаагаар таслуулах	723	826
	Гэрээ танхим	Шинээр гэрээ байгуулах, гэрээний нэр солиулах, ангилал солиулах	88	221
	Борлуулалт	Бичилтийн дахин шалгуулах, төлбөр тооцоотой холбоотой	444	280
		Тоолуурын заалтыг харах	3	15
	Орлого	Кодоо болон байгууллагаа буруу сонгож төлбөр, төлбөр төлөхдөө орон андуурч илүү төлсөн залруулга	384	557
	Тарифын хөнгөлөлт эдлэх	Нийгмийн халамжийн туслалцаа шаардлагатай тарифын хөнгөлөлт эдлэх	55	225
	Хууль дүрэм журам зөрчсөн	Шийдвэрлэх боломжгүй	8	27
Гомдол	Техник үйлчилгээ	Цахилгаан хангамжийн чанартай холбоотой	2	11
	Борлуулалт	Бичилт нэхэмжлэх тооцоотой холбоотой	18	26
	Орлого	Орлого хуваарилалттай холбоотой	3	5
	Хэмжих хэрэгсэл	Ажиллагаа алдагдсан	0	0
	Үйлчилгээ, харилцаа	Ажилтаны зан харьцаатай, үйлчилгээтэй холбоотой	0	0
Санал	Үйлчилгээ, харилцаа		0	0
	Талархал		2	16
Бүгд			1730	2209

Тав. Мэдээлэл технологийн чиглэлээр

5.1 Мэдээллийн аюулгүй байдал чиглэлээр


- 2019.01.29-нд Kaspersky EndPoint вирусн програмыг худалдан авч / 145 хэрэглэгч, 9 сервер / салбар нэгжүүд болон серверүүдэд суурилуулсан



- ITZONE ХХК-тай Firewall худалдан авах гэрээ байгуулж, урьдчилгаа шилжүүлж, захиалга өгч ITZONE 2 инженер 2019 оны 03 сарын 12-14-ний өдрүүдэд ажиллаж Firewall тохиргоо хийлгэж, хүлээн авсан



- Dsedn.mn, <https://tsakhilgaan.mn>, SSL тохиргоог 1 жилийн хугацаагаар сунгасан.



- Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой 21 ширхэг стандартыг мэдээллийн аюулгүй байдлын бодлого, мэдээллийн аюулгүй байдлын дүрэм журам боловсруулах болон өдөр дутмын үйл ажиллагаандаа ашиглан хэрэглэж байна.
- 2019 оны эхний хагас жилийн байдлаар Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК-ийг мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн түвшин, сервер зохион байгуулалт болон тэдгээрийн хамгаалалтын байдлыг тодорхойлсон тайланг шинэчлэн гаргасан.
- “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”, “Ухаалаг тоолуурын системийн аварийн нөхцөлд ажиллах журам”-ыг боловсруулан батлаж мөрдөн ажиллаж байна. Мөн мэдээллийн системийг ашиглах талаар заавар зөвлөгөөг тодорхойлсон “Мэдээллийн аюулгүй байдлын нэгдсэн журам” -ыг боловсруулан батлахад бэлэн болсон.
- Дотоод сүлжээний бүтэд зохион байгуулалтыг өөрчилсөн – Урьд нь сервер болон дотоод сүлжээ нэг сүлжээнд байсныг салгаж серверүүдийг DMZ сүлжээнд, дотоод сүлжээг LAN сүлжээ болгон салгаж өгснөөр дотоод сүлжээнээс DMZ сүлжээ рүү хандсан урсгалыг хянах боломжтой болсон. Мөн өрөө болгонд байдаг WIFI рүэтэруудийг LAN сүлжээний хаяг тараадаг болгож өөрчилсөн. Ингэж өөрчилснөөр WIFI рүэтэрийн цаана байгаа нөүтбүүк болон гар утас таблетуудыг хянах бүрэн боломжтой болсон.
- Салбаруудыг компанийн төвтэй холбож буй VPN туннэлийг илүү нууцлатай IPSec протокол ашиглан холбосон. Энэхүү ажлыг хийснээр салбараас серверүүд рүү хандсан хандалтууд илүү нууцлагдан дамжигдах болсон.
- “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого” - ыг боловсруулан батлуулан мөрдөн ажиллаж байна. Мэдээллийн аюулгүй байдлын бодлоготой болсноор мэдээлэл, мэдээллийн системийг зүй бус халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нөхөн сэргээх үйл ажиллагааны механизмыг бүрдүүлээд байна.

ДСЦТС ХК-ийн мэдээлэл боловсруулах аппарат хэрэгслүүд: (Шинэчлэгдсэн)

➤ Системүүд

1. Борлуулалт арилжааны систем
2. Хэрэглэгчийн онлайн систем
3. Тоолуурын хяналт удирдлагын систем - HES
4. Нэгтгэлийн програм хангамж
5. Хүний нөөцийн програм хангамж
6. Техник ашиглалт засвар үйлчилгээний програм
7. Диспетчерийн хяналтын систем
8. Эрчим хүчний системийн дүн шинжилгээний програм хангамж
9. Санхүү эдийн засгийн цогц систем
10. Тээврийн хэрэгслийн хяналтын систем
11. Хяналтын камерын систем

➤ Сервер компьютерууд

1. (HES) Тоолуурын хяналт удирдлагын системийн AMR Server
2. (HES) Тоолуурын хяналт удирдлагын системийн Database Server
3. (HES) Тоолуурын хяналт удирдлагын системийн Web Server
4. (SCADA) Диспетчерийн хяналтын системийн сервер
5. (EDIMIS) Борлуулалт арилжааны системийн сервер
6. (CFS) Санхүү эдийн засгийн цогц системийн сервер
7. (CIS) Хэрэглэгчийн онлайн системийн сервер
8. (HR) Хүний нөөцийн програм хангамжийн сервер
9. (Domain name) Домайн нэр сервер

➤ Сүлжээний төхөөрөмжүүд

1. Галт хана буюу Fortigate 500E Firewall
2. Чиглүүлэгч буюу CCR1009-8G-1S Router
3. Чиглүүлэгч буюу RB850G Router
4. Workstation компьютерууд
5. RTU MGateway MB3820
6. Радио линк буюу Airfiber AF-5 Radiolink
7. Радио модем буюу PowerBeam 5AC 500
8. Радио модем буюу PowerBeam 5AC 300
9. Access point RB433АН
10. Тасалдалгүй тэжээлийн аппарат буюу UPS-10kVa
11. Мэдээлэл дамжуулах концентратор
12. RV042 Vpn Cisco Router

➤ Дэд бүтцүүд


1. Өөрийн болон МХС компанийн шилэн кабель
2. Өөрийн радио сүлжээ бүхий Радио линкүүд
3. Өөрийн компанийн RS485 сүлжээ
4. Үүрэн холбооны операторуудын 3G, 4G сүлжээ

➤ Байр, байршил

1. Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК төв оффис 3-р баг
2. Дархан Хэрэглэгчдэд үйлчлэх Төв-1 2-р баг
3. Дархан Хэрэглэгчдэд үйлчлэх Төв-2 14-р баг
4. Цамхаг-1 буюу Дархан сум 5-р баг
5. Цамхаг-2 Дархан сум 15-р баг
6. Цамхаг-3 Дархан сум 14-р баг

5.2 HES-д хийгдсэн ажлууд

- 2019.06.17-19 нд HES системийн функцуудыг Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлсэн





HES системийг суулгасны дараа системийг шалгаж турших ажил эхэлсэн. Уг ажлын хүрээнд дараах зүйлсийг сайжруулах санал гаргаж ажилласан.

1. Тоолуурын заалтыг дэс дарааллаар харуулах
2. Ачаалал хянах функцэд чадлын K нэмэх
3. Ачаалал хянах функцэд хүчдэл, гүйдлийн тр-н утга нэмэх
4. Тоолуурын заалт бүрэн биш байсан тул засуулах
5. Концентраторын бүртгэлд засвар хийж болохгүй байсныг засуулах
6. Концентраторын дотоод бүртгэлд тоолуур нэмэх функцийг ажиллагааг хэвийн болгох
7. Тоолуурын бүртгэлд засвар хийж болохгүй байгааг хэвийн болгох
8. Тоолуурын заалт Excel файлууд хөрвүүлэхэд дэс дугааргүй гарч байгааг засуулах
9. Тоолуурын ачааллын утга буруу байгааг засуулах
10. Алдагдлын функцэд тоолуурын нэр код оруулах
11. Алдагдлын функцэд оролт гаралтын зөрүүг тоогоор харуулах
12. Тоолуурын өдөр бүрийн заалт таталтын хувь хэмжээ буруу байсныг засуулах
13. Бүртгээгүй боловч холбогдох боломжтой концентраторыг харуулах функц нэмүүлэх
14. Тоолуурын заалт харуулах функцэд гучин үзүүлэлт харагддаг байсныг сонголтоор харуулах боломжтой болгох
15. Тоолуурын ачаалал харуулах функцэд бутархай утга 12 оронтой байсныг 4 болгох
16. Тоолуурын заалт алдаатай харуулж байсныг засах
17. Тоолуурын заалт давхцаж харуулж байгааг засах
18. Тоолуурын заалт олон хоногоор харуулахдаа алдаатай байсныг засуулах
19. Зарим концентраторын заалт орж ирэхгүй байгааг засуулах
20. Тоолуурын марк буруу сонгогдсон тоолууруудыг засуулах
21. Хайх функцэд тоолуурын марк оруулах
22. Тоолуурт тохиолдсон үйл явдлын тайлан мэдээ алдаатай байгааг засуулах

НЕС системд хандах эрх бүхий ажилчдад тус бүрийн ажлын онцлогтой уялдуулан нэвтрэх эрх нээсэн.

- Борлуулалтын ажилтан
- Авлагын ажилтан
- Диспетчер
- Салбарын тоолуур системийн инженер
- Админ
- Хяналтын ажилтан
- Тоолуурын инженер

гэсэн 7 төрлийн эрх нээж, одоогийн байдлаар салбар төвийн 45 ажилтанд НЕС системд нэвтрэн ажиллах эрх үүсгээд байна.



HES системийн сургалт нэвтрүүлэлтийн ажил:

Хятад инженерүүдтэй 2019.07.25-2019.08.08 Чадлын заалт татах ажлыг FTP сервер зохион байгуулан татдаг болсон. Ингэснээр 4 цагийн хугацаанд татдаг байсан мэдээллийг 15 минутанд татаж харуулдаг болсон



HES системийн дэлгэрэнгүй сургалтыг Shenzhen CIOU компанийн мэргэжилтэнтэй хамтран явуулсан. Уг сургалтанд салбар төвийн тоолуур сүлжээний инженерүүд хамрагдсан.

8 сарын 2-3-ны хооронд

Date	Time	Speaker	Participant	Topic	Content	Environment
Day 1	10:00 AM - 12:00 PM	LIAOWENHU	Technical Support, System Operator, System user	CloudESP HES Introduction and Basic Functions	Introduction HES 1. Introduction AMI Solution 2. Architecture overview 3. What can HES do for you? 4. Support AMI Device and Open Standards 5. Integration MDM, PPM, DCU, Meter 6. Key Functions 7. UI Show	PPT
		LIAOWENHU	Technical Support, System Operator, System user		Basic Functions 1. Deployment Management 2. Provisioning 3. Schedule Reads 4. Device Configuration 5. CDC 6. On-demand Reads 7. Synchronization Time	PPT Clou Unified Demonstration Platform
	1:30 PM - 3:30 PM	LIAOWENHU	Technical Support, System Operator, System user	CloudESP Installation and Configuration	CloudESP Installation and Configuration 1. HES Installation 2. HES Configuration 3. Current HES Deployment Overview	CloudESP HES Installation & Configuration Manual
	3:30 PM - 4:30 PM	LIAOWENHU	Technical Support, System Operator, System user	Q&A		N/A
Day 2	10:00 AM - 12:00 PM	LIAOWENHU	Technical Support, System Operator, System user	System Troubleshooting	UI log 1. Metering Tracing Log 2. Time Synchronization Log 3. System Level Log 4. Common issue introduction	Local AMI Device Clou Unified Demonstration Platform
		LIAOWENHU	Technical Support, System Operator, System user	Practice and Q&A	System Check Practice Q&A	Local AMI Device Clou Unified Demonstration Platform

- HES системийг жигдрүүлэх ажлын хүрээнд дараах үл тохирлуудыг илрүүлж, засварлах ажил хийгдэж дууссан.
 - 3 фазын 100A тоолуурын ачааллын утга дутуу ирж байгаа

- Тоолуурын бүртгэлийн хэсэгт хэрэглэгчийн код, концентратор дах дэс дарааллын дугаар оруулах
- Мини концентраторын бүртгэл засах
- Зарим тоолуурын заалт буруу ирсэн
- Зарим тоолуурын заалт ижил байсан
- Ачаалал татах функцэд чадлын коэффициент оруулах
- Хайлтын функцэд тоолуурын модел оруулах
- Тасархай залгаатайг харуулах хэсэгт тоолуурын жагсаалт дутуу орж ирсэн
- Тоолуурын бүртгэлийн хэсэгт СТ/РТ оруулах
- Тасархай залгаатайг харуулах хэсгийн тасархай тоолуурын нийлбэр буруу
- Тайлангийн хэсэгт олон тайлан давхацсан
- Заалт харах хэсэгт тоолууруудыг дэс дарааллаар харуулах
- Орон сууцны тоолууруудын заалт дутууу харагдаж байсан
- Концентраторын бүртгэлд өөрчлөлт хийх боломжгүй
- Концентраторын бүртгэлээс тоолуур устгаж болохгүй байсан
- Концентраторлуу тоолуур зааж өгөх функц ажиллахгүй
- 1 фазын тоолуураас ачаалал авч болохгүй байсан
- Онцгой хэрэглэгчийн хайлтын хэсэгт концентраторын нэр нэмэх
- Онцгой хэрэглэгчээр бүртгэсэн боловч орж ирэхгүй байгаа
- Excel файлуруу хөрвүүлэхэд дэс дарааллын тоо гарч ирэхгүй байгаа
- Ачааллын утга буруу коэффициентээр үржигдэж байгаа
- Ачааллын утгын бутархай орныг цөөлөх
- Концентраторын зааж өгөх болон унших функц ажиллахгүй байгаа
- 3 фазын тоолуурын СТ утга буруу
- Бага хугацааны давтамжтай програмаас гарч байгаа
- Заалт татаагүй тоолуурын жагсаалт харуулах хэсэгт тоолуур, концентраторын нэр оруулах
- Зөвхөн өөрийн харьяа хэсгийн үзүүлэлтийг харах
- Тоолуурын заалт татсан хувийг харуулсан утга буруу
- Зөвхөн өөрийн харьяа хэсгийн тайланг харах
- Нийлүүлсэн ЦЭХ-г харуулах тайлан нэмэх
- Тоолуурын бүртгэлд өөрчлөлт хийж болохгүй байгаа
- Бүртгээгүй байгаа холбогдох боломжтой концентратор харуулах тайлан нэмэх
- Хэрэглэгчийн үйлдэл бүртгэх хэсэгт зөвхөн програмд нэвтэрсэн болон гарсан бүртгэлийг харуулж байна.
- Концентраторын бүртгэл устгах боломжгүй байна
- Тоолуурын заалт буруу татагдсан
- Тоолуурын холболтын протокол буруу
- Тоолуурын заалт татсан тайланг ихээс багаруу ангилах
- Зарим концентратор 00:00 цагийн заалтаа хадгалахгүй байна
- Excel файлуруу хөрвүүлэхэд дэс дарааллаар харуулахгүй байна
- Ачаалал татах хэсгийн цаг буруу
- Шугамын алдагдлын хэсэгт хэрэглэгчийн код оруулах
- Шугамын алдагдлын хэсэгт ялгавар оруулах
- Login overtime алдаа байнга заж байгаа
- Заалт харуулах хэсэг хоосон болсон
- Тухайн эгшний утга харуулах хэсэгт дэс дарааллын дугаар оруулах


- Програмын функцээс бусад бичиглэл хэт жижиг фонттой болсон
- Тариф тохируулах хэсгийг харуулах
- Трансформаторын алдагдал бодох хэсэгт хуучин системээс хөрвүүлэлт хийх

5.3 Сервер орчны чиглэлээр

- 2019.01.31 нд серверийн өрөөнд утаа гарсан дуудлагын дагуу ажиллахад БАС-ийн сэнс шатсныг тодорхойлж, сэнс захиалан авч серверт суурилуулсан
- 2019.02.18 ны 21:00-06:30 цагийн хооронд серверийн өрөөний сүлжээний кабелийг цэгцэлж, серверүүдийг өндөр ракад суурилуулж, програм хангамжийг хэвийн ажиллагаанд оруулсан.
- 2019 оны 01 сарын 29-нд 3 сервер худалдаж асуудлыг техникийн зөвлөлөөр оруулан батлаж, 2019.03.07-нд Серверийн техникийн үзүүлэлтийн судлаж R740 маркийн Dell брендийн 3 сервер, рак 49,200,000 төгрөгөөр худалдан авч ракад суурилуулсан.



- Програм хангамжийн өгөгдлийн баазыг сар бүрийн хаалт хийсний дараа нөөцөлж QNAP сервер лүү хуулсан. Серверийн ашиглаж байгаа багтаамж 352Gb мэдээлэл хадгалж байна.



5.4 Борлуулалт арилжааны системийн талаар
2019.01.08 нд ББЗХ-ийн баазыг ШИН-ийн борлуулалт, ААН-ээр Борлуулалт арилжааны системд салгаж, Нэгтгэлийн програм хангамжинд салгасан баазууд холбож ажилд оруулсан.




Салбар: Дархан-ХҮТ

Хэрэглэгч: Зүүнхараа
Сүхбаатар

Нууц үг: Шин ААН
Хөтөл
Жаргалант
ББЗХэлтэс

- Улаанбаатар даатгалын хураамжийн гэрээ байгуулах модулийг борлуулалт арилжааны системд шинээр оруулах ажлыг 2019 оны 01 сарын 29-ний өдөр модулийг нэмж оруулж, гэрээний мэргэжилтэнд програмд ажиллах зааварчилгаа өгсөн



Код:

Овог: Нэр:

Иргэний үнэмлэхний №: Регистр:

Шалтгаан: Даатгал гэрээ байгуулах


Тооцох тоо: 1

Тооцох үнэ: 1500.0000

Тайлбар:

Хадгалах Хаах

- 2019.04.03 нд Сүхбаатар салбарын БАС-д хогны мөнгөний хураамжийг авахгүй болгож хаасан.
- 2019.04.05 нд БАС-д шөнийн хөнгөлөлтийг өөрчлөлт оруулав
- 2019.05.06.07 саруудад ЭХЗХ-ноос үнэ тариф өөрчлөгдсөн холбогдуулан БАС болон урьдчилсан төлбөрт тоолуурын програм хангамжийн үнэ тарифийг тухай бүр нь өөрчлөж нягтлангуудад зааварчилгаа өгсөн






- 2019.02.01 нд Уул уурхайн үнэ тарифийг 25000 төг болгон өөрчилсөн
- 2019.03.12 нд НӨАТУС-ын баримтыг хэрэглэгчийн утасны дугаар руу илгээх, файлын бус орлогыг хүлээн авах IACD Import Account Credit Data програм хангамжийг салбар, ХҮТ-д нэвтрүүлэв.


ДСЦТС ХК Сэлэнгэ | Үндсэн | НӨАТУС | Мессеж илгээх жагсаалт | И-мэйл илгээсэн түүх | Гаргах

Эхлэх огноо: 2019/04/01 | Дуусах огноо: 2019/04/04 | [Харах](#) | Гарын авлага

Гүйлгээний жагсаалт

Хэрэглэгчийн код	Регистр	Нэр	Мөнгөн дүн	Огноо	Сугалааны дугаар	ДДТ	
5000010	МЮ50061016	Л ТӨМӨРБААТАР ХӨРӨӨ	18800	2019/04/02 07:17	SV 66093803	000002688565124190404992001101387	 Хэвлэх
5000520	НБ88113010	ЭНХБАЯР	17200	2019/04/02 10:03	SV 66094892	000002688565124190404992001101388	 Хэвлэх
5000711	МЮ 67120595	ГАНТУВШИН	15000	2019/04/02 12:00	SV 66095983	000002688565124190404992001101389	 Хэвлэх

- 2019.09.11 нээс Гэрээ, танхимын програм хангамж, борлуулалт, тоолуурын програм хангамжуудын шинэчлэлт хийгдсэн



- “Дархан Сэлэнгийн ЦТС” ХК болон програм хангамжийн “ECM” ХХК нарын хооронд 2019 оны 05 сарын 01-ний өдөр байгуулсан №19/58 тоот гэрээт ажлыг гүйцэтгэж, гүйцэтгэл 95%-тай ажиллаж байна



5.5 Хүний нөөцийн програм хангамжийн талаар

Able програм хангамжийг нэвтрүүлж онлайнаар 3 удаа, сургалтын инженер ирж 1 удаа сургалт явуулсан. Цаг бүртгэлийн төхөөрөмжийг компанийн төв, Дархан ХҮТ-ийг 2019.01.21 нд холбож ажиллуулсан. 2019.04.03 нд Сүхбаатар салбар, Зүүнхараа салбар, Жаргалант салбар, Хөтөл салбар, Шарын гол хэсэгт суурилуулж ABLE програмтай холбосон

Код	Ажилтны нэр	Албан тушаал	Ирсэн	Явсан	
Цаг бүртг...	+ Ажилтны нэр	...	Ажилтны албан туша...	Ажилда...	Ажлаас ...
032030	Л.Лхагвасүрэн	Зүүнхараа салбарын	07:47 ²²	17:27 ¹⁷	
032108	Б.Баярсайхан	Мастер	07:45 ²⁴	17:47 ³⁷	
032120	Г.Хос-Учрал	Ахлах ня-бо	07:45 ²⁴	17:54 ⁴⁴	
032164	Б.Алтаноүх	Борлуулалтын ня-бо	07:40 ²⁹	17:43 ³³	

5.6 Диспетчерийн хяналтын системийн талаар

Сүхбаатар, Жаргалант, Зүүнхараа салбарт склада системийн дэлгэц дээр чадлын утга гаргаж хянадаг болгосон.



35/6кВ-ын Өгөөмөр дэд станцын нийт тэжээлтэй байгаа 13 ячийкийн скада камерийн системийн холболт угсралтыг хийж ашиглалтанд оруулсан. ачаалал ихтэй Өгөөмөр дэд станцад скада систем суурилуулсанаар ачаалал, таслалт залгалт, шиний газардлага зэргийг мэдээллэдэг болсон.

Хөтөл салбарын РП-1 ХБ-ийн скада камерийн системийн мантаж таслуурын холболтуудыг шинээр хийж төв серверт холбосон.


Зүүнхараа РП-1 ХБ-ийн барилгын засвар хийсэнтэй холбоотой Скада камерийн системийн мантаж угсралтын ажлын шинээр хийж гүйцэтгэсэн.

Зүүнхараа РП-1 ХХБ

Хөтөл РП-1 ХХБ




Хөтөл салбарт скада системийн дэлгэц дээр чадлын утга гаргаж хянадаг болгосон. Хөтөл салбарт Цагааннуур, Орхонтуул дэд станц , РП-1 ХБ-аас мэдээлэл авч байна.



Диспетчерийн хяналтын дэлгэцийн харагдах байдал, схемийг өөрчилсөн.

- 35кВ-ын ачааллын урсгал - актив, реактив чадал, cosφ зэрэг функц нэмэгдсэн.
- Гүйдлийг 35кВ болон 6/10кВ-оор ялган харагддаг болсон.
- Хамгаалалтаар тасарсан шугамыг МТО, МТЗ-I, II шатаар, газардлагын хамгаалалт зэрэгээр ялан мэдээллэх боломжтой болсон
- Дэлгэц дээр тухайн дэд станц ХБ-ийн оролтын таслуурын төлөвийг харах боломжтой болсон.
- Графикаар нийт актив, реактив чадал, 35кВ, 6кВ-ын гүйдлийн харуулж байна.



Аварийн бичлэг, тайлан гаргах функцийг судлан өөрийн Demo хувилбар дээр туршин ажиллаж байна.

Дэд станц хуваарилах байгууламжийн скада систем хүчдэлгүй болсоноор скада мэдээллэх боломжгүй байгаа учраас тог баригч UPS суурилуулж эхлээд байна.

- 35/6кВ Хонгор дэд станц
- Шарын гол РП-1 ХХБ
- Зүүнхараа РП-1 ХХБ
- Хөтөл РП-1 ХХБ 91111748

2019 онд багтаан бусад дэд станц ХБ-д тог



ж дуусна.



Эргүүл үзлэгийн графикийн дагуу

- 1-р сард: Радио цамхаг 1,2,3
- 2-р сард: Дархан доторхи РП, 35кВ-ын дэд станцууд
- 3-р сард: Сүхбаатар салбар, Шарын гол, Хүдэр, Жимс, Хонгор дэд станцуудын тоноглолд
- 4-р сард: Дархан доторхи РП, 35кВ-ын дэд станцууд
- 5-р сард: Зүүнхараа , Жаргалант салбарын 35кВ-ын дэд станцуудын тоноглолд
- 6-р сард: Сүхбаатар салбар, Шарын гол, Хүдэр, Жимс, Хонгор дэд станцуудын тоноглолд үзлэг хийсэн. Үзлэгийн тайлан техник ашиглалтын програмд тогтмол оруулж ажилласан.

5.7 Мэдээлэл холбоо, сүлжээний талаар


2019.01.10 ны өдөр Харилцаа холбооны зохицуулах хороонд Радио долгионы тусгай зөвшөөрөл сунгах албан бичиг, өргөдөл, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж өгсөн. Хариу шийдвэр 20 хоногийн дотор гарна. ХХЗХорооны радио долгионыг ашиглах эрхийг сунгах шийдвэр гаргаж гэрчилгээг 2 жилээр сунгаж авав.

- 2019.01.31-нд Компанийн интернэтийн хурдыг Мобинэт рүү хүсэлт гаргах компанийн интернэтийн хурд 35Mbps, салбаруудын интернэтийн хурд 8Mbps болгосон.
- 2019 оны 1 сар компанийн төвийн интернэтийн хурд нэмэгдлээ.
Мобикомын корпораци ХХК-ийн ашиглаж байгаа интернэтийн хурдыг шинэчилсэн гэрээ хийж 1.5-2 дахин өсгөсөн.
- Сервэрийн өрөөнд орчны хяналтын систем суурилуулсан.
 - Орчны хяналтын систем суурилснаар өрөөнд ус алдах, гал утаа, температур өөрчлөгдөх, хаалга онгойх, хүчдэл тасрах болон хөдөлгөөн илэрэх үед мэдэрч мессеж илгээх мэдээллийг авдаг болсон.
- 2019.04.01 нд Урсдаг лед дэлгэцийн тэжээлийн блокыг сольж ажилд оруулсан
- 2019.04 сард Дархан ХҮТ-II шинэ байранд орсонтой холбогдуулан шилэн кабель холбох, сүлжээний зохион байгуулалт хийж, гадна хаяг суурилуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн
- 2019.05.14 нд Компанийн гадна байрлах үйлчлэх хүрээний зургийг зурж, эх бэлтгэн хэвлэлтэнд өгч тогтоосон

5.8 Ухаалаг тоолуур

Компанийн хэмжээнд 2019 оны 11-р сарын байдлаар HES системд бүртгэлтэй ухаалаг тоолуур, концентраторын судалгаа

Салбар нэгж	Концентраторын тоо	3 фазын ухаалаг тоолуур	1 фазын ухаалаг тоолуур
Дархан ХҮТ	367	957	25876
Сүхбаатар	44	108	4251
Хөтөл	47	87	2745
Жаргалант	44	147	3237
Зүүнхараа	49	194	22
ББЗХ	18		
МТАА	6	1	26
НИЙТ ТОО	575	1516	40986





Зургаа. Олон нийт, хэвлэл мэдээллийн ажлын чиглэлээр

6.1. Олон нийтийн ажлын талаар

2019.01.27- "МӨНГӨН ӨВӨЛ-МӨСНИЙ БАЯР-2019" ЭРҮҮЛ АЖИЛТАН-ИХ БҮТЭЭМЖ УРИАН ДОР ЗОХИОН БАЙГУУЛСАН.

Манай компани жил бүр ажилчдынхаа бие бялдрыг хөгжүүлэх чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх зорилгын хүрээнд цас мөсний баярын арга хэмжээг зохион байгуулдаг уламжлалтай. Мөн Эрчим спорт зааландаа 7 хоног бүр бэлтгэл сургуулалт хийгдэж тэмцээн уралдаанынуудыг улирал тутамд зохион байгуулдаг биеийн тамирыг дэмжигч байгууллага билээ. Энэ жилийн мөсний баяр Цагаан нуурын дэнжид зохион байгуулд морин барилдаан, олс татлт, хөгжилтэй буухиа зэрэг олон төрлийн тэмцээн уралдааныг зохион байгууллаа. Мөсний баярт Дархан дахь салбар нэгжийн ажилтнууд идэвхитэй хамрагдаж эрүүл агаарт дасгал хөдөлгөөн хийж нэг өдрийг хөгжилтэй өнгөрүүллээ. Тэмцээн уралдааны багийн дүнгээр тэргүүн байранд Хэмжүүр тоолуурын лаборатори-Шуурхай үйлчилгээ мэдээллийн албаны хамтарсан баг, дэд байрт Засвар туршилт тохируулгын алба, гутгаар байрт Дархан түгээх төв тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналын эзэд боллоо.

АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛСЭН.

2019.01.31-ний өдөр Урвуулагч хэмээх Шаргачин гахай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан ДСЦТС ХК-д залуу насаа зориулан ажилласан 50 гаруй ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлж хүлээн авлаа. Залуучууд театрын уран бүтээлчид ая дуугаа өргөж, компанийн удирдлага, ажилтнууд мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд өнгөрч буй шороон нохой жилийн ололт амжилтынхаа талаар танилцууллаа. Манай компанийн тухайд ахмадуудаа жилд 2 удаа хүндэтгэн хүлээн авч үгийг нь сонсон ололт амжилт алдаа дутагдлынхаа

талаар ярилцдаг уламжлалтай билээ. Энэ жилийн тухайд ахмадууд Ахмадын зөвлөлийнхөө дотоод сонгуулийн санал хураалтын ажлаа энэ үеэр зохион байгуулж Ахмадын зөвлөлийн даргаар Д.Цэцэгээ дахин сонгогдлоо.

ШАРГАЧИН ГАХАЙ ЖИЛИЙН САР ШИНИЙН НЭГДСЭН ЗОЛГОЛТ БОЛСОН.

17-р жарны шаргачин ГАХАЙ жилийн сар шинийн баярын компанийн нэгдсэн золголт боллоо. Монголчууд Сар шинийн баяраар ахмад настнаа хүндэтгэн золгож тэгш дүүрэн буян заяаг бие биедээ бэлгэдэж, амар мэндийг мэдэж, ерөөлийн сайхан үгсийг хэлэлцэн эрчим энергийг хүртдэг уламжлалтай. Энэ дагуу ДСЦТС ХК-ийн хамт нэгдсэн золголтоо зохион байгуулж Монгол өв соёлоо залуучуудад таниулсан тэмцээн уралдаануудыг зохион байгууллаа

"СПОРТЫН НААДАМ-2019"-ЫН АВАРГААР ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН АЛБА-ХЭМЖҮҮР ТООЛУУР ЛАБОРАТОРИЙН АЛБАНЫ ХАМТАРСАН БАГ ШАЛГАРСАН.

2019.02.14-17-ны өдрүүдэд ДСЦТС ХК-ийн 5 төрөлт спортын наадам зохион байгуулагдлаа. Сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, шатар, билльярд зэрэг төрлүүдээр 11 салбар нэгж хэсгийн 200 гаруй тамирчид өрсөлдсөнөөс Хэмжүүр тоолуурын лабораторийн алба, Шуурхай үйлчилгээ мэдээллийн албаны хамтарсан баг аваргаар шалгарч үүрд хадгалагдах цомын эзнээр шалгарлаа.



2019 оныг салбарын хэмжээнд Эрчим хүчний яамнаас “Ухаалаг эрчим хүчийг нэвтрүүлэх жил” болгон зарлаж, мэдээллийн технологийн дэвшилтэт арга хэрэгслүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд манай компанийн туршлага, үйл ажиллагааг судлахаар 10 гаруй байгууллагын 100 гаруйзочид төлөөлөгчдийг хүлээн авлаа.

"DDS LEAGUE-2019" ТЭМЦЭЭНИЙ АВАРГА БОЛЛОО. Волейболын баг тамирчид ДДС ТӨХК-ийн нэрэмжит "DDS LEAGUE-2019" тэмцээнд амжилттай оролцож, аваргын алтан медалийг хүртэн, шилжин явах цомын эзэн боллоо. Алтан медалийн төлөө Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-тай тоглож 3:0 харьцаатай ялалт байгуулсан. Мөн лигийн тэмцээний шилдэг тоглогчоор ДСЦТС ХК-ийн тамирчид Д.Алтанхуяг шалгарч өргөмжлөл мөнгөн шагналын эзэн боллоо.

ГАМШГИЙН ҮЕИЙН ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДУУТ ДОХИОГООР 100 %-ИЙН ИРЦТЭЙ АЖИЛЛАЛАА. Монгол улсын Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын дагуу Гамшгийн үед зарлан мэдээллийн дохиогоор нэгэн зэрэг ажиллах сургалтыг жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагт улс орон даяар гамшиг, ослын дуут дохиог ажиллуулж, гамшгийн үеийн бэлтгэл сургуулилт хийдэг. Энэ жил уг өдөр 21-нд тохиож байгаа бөгөөд 16:00 цагт улс даяар нэгэн зэрэг зохион



явууллаа. Улс орон даяар зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, түүнд хамрагдаж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог дээшлүүлэх зорилгоор аймгийн Онцгой байдлын газраас энэ дадлага, сургуулийг ес дэх жилдээ зохион байгуулж байгаа юм. Газар хөдлөлтийн гамшгийн аюул тулгарсан үед ААНБ-ын бэлэн байдлыг хангуулах, Дархан-Уул аймагт суурилуулсан төвлөрсөн зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдал үйлчлэх хүрээг шалгах, иргэдийг гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллуулж сургах ач холбогдолтой тус үйл ажиллагаанд ДСЦТС ХК-ийн хамт олон 100 %-ийн ирцтэй оролцож бэлэн байдлаа шалгууллаа.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОЖ ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН.

Олон улсын хэрэглэгчийг хамгаалах байгууллагаас 2019 оныг “Аюулгүй ухаалаг, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ”-ний жил болгосон. Энэ хүрээнд аймгийн ЗДТГ, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран Аюулгүй ухаалаг, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр сургалт, сурталчилгааг явуулж эхэлсэн. Энэхүү арга хэмжээнд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр иргэдийг хангаж иргэдийн сонирхсон асуултанд хариулт, лавлагаа мэдээлэл өглөө. Түүнчлэн өдөрлөгийн үеэр хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч хэрэглэгчдийн саналыг үйл ажиллагаандаа тусган ажиллахаар болсон юм
"ЭХ ОРОН ТАНААС ЭХЭЛНЭ" СЭДЭВТ ЛЕКЦ БОЛЛОО

ДСЦТС ХК-ийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар Улаанбаатар хотоос доктор, профессор Б.Гүнбилэг "Эх орон танаас эхэлнэ", Б.Даваасүрэн "Дадал хэвшил бий болгох 100 хоног" Г.Баттулга Зөрчлийн менежмент зэрэг сонирхолтой сэдвээр лекц сургалтыг зохион байгууллаа. Лекцэнд 100 гаруй ажилтнууд хамрагдаж сонирхолтой мэдээллүүдийг авлаа. Ажилтнууд ажил амралтаа зөв зохицуулах, зөв дадал хэвшлийг амьдралдаа бий болгон стрессээ хялбар аргаар тайлан эрч хүчтэйгээр бүтээмж дүүрэн хэрхэн ажиллах чиглэлээр тус лекцийн үеэр яригдсан юм.

НЭГДСЭН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖИЛТЫН АУДИТАД ТЭНЦЭН ISO9001:2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО, ISO45001:2015 ХЭМАБ-ЫН УДИРДЛАГЫНН ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТУУДЫГ НЭГДМЭЛ БАЙДЛААР НЭВТРҮҮЛСЭН АНХНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГА БОЛСОН ЮМ.



"ЖАРГАЛТАЙ ҮРС" ХҮҮХДИЙН БАЯРАА ТЭМДЭГЛЭЛЭЭ

2019.05.31-ний өдөр Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн хамт олон бяцхан үрсээ хүлээн авч хүндэтгэл үзүүлэн олон төрлийн тэмцээн уралдаан, урлагийн тоглолтыг зохион байгууллаа. ДСЦТС ХК -ийн нийт ажилтнуудын хүүхдүүд 500 гаруй байдгаас Дарханы төвийн хэсэгт 300 гаруй хүүхдүүд

байдаг. Эдгээр хүүхдүүддээ зориулан "Жаргалтай үрс" үйл ажиллагааг Эрчим спортын ордондоо зохион байгуулж Хүүхэд хөгжлийн ордон, Залуучууд театрын дэргэдэх Деонис жүжгийн дугуйлангийн авьяаслаг хүүхдүүдийн тоглолтоор бэлэг барьж, дугуй, гүйлт, гар зургийн уралдаануудыг зохион байгуулан аваргуудыг тодрууллаа. Мөн танин мэдэхүйн АХА тэмцээнийг хүүхдүүдийн дунд зохион байгуулж бүх хүүхдүүд бүжиг дуу сурч хамтдаа хөгжилдлөө.

"УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЦГӨӨ" АЯН ДСЦТС ХК-ААС ЭХЭЛЛЭЭ

Дархан-Уул аймгийн ИТХ, ЗДТГ-аас 2019 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон зарласан. Үүнтэй холбогдуулж Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг иргэд олон нийтэд таниулан сурталчлахаар Угийн бичгээ хөтөлцгөө аяныг аймгийн хэижээнд зохион байгуулсан юм. Тус аяны дэвтэр Дархан -Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага хувийн хэвшлийн нийт 100 гаруй байгууллагуудаар аялсан. Аяны дэвтрийг 2019.05.30-ны өдөр аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ДСЦТС ХК-д хүлээлгэн өглөө.



ЭРЧИМ ХҮЧНИЙ БАЯРЫН ТЭМЦЭЭНД ЖАРГАЛАНТ САЛБАР ТЭРГҮҮЛЛЭЭ

Монгол улсад эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 97 жил, Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК байгуулагдсаны 54 жил, Дархан Хэрэглэгчдэд үйлчлэх төв, Дархан түгээх төв байгуулагдсаны 6 жилийн ой Эрчим хүчний баярын үйл ажиллагаа Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Зүүн шандад 2019.08.16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Эрчим хүчний баяр хүчит 64 бөхийн барилдаан, сурын харваа, шагайн харваа, хөлбөмбөг гэсэн төрлүүдээр аваргуудаа тодруулж эрчим хүчний салбарын ажилтнууд 2 өдрийг агаар салхинд алжаалаа тайлан өнгөрүүлээ. Тэмцээн уралдааны шилдгээр Жаргалант салбар шалгарч шилжин явах цомын эзэн болсон бөгөөд олон шинэ залуу ажилтнууд бөх, сур, шагайн харваа хөлбөмбөгийн төрлүүдээр хурд хүчээ сорин нөхөрсөгөөр өрсөлдсөн юм. Энэ жилийн баярын хүчит 64 бөхийн барилдааны шөвгийн дөрөвт Засвар туршилт тохируулгын албаны 4 бөх шалгарч Булган аймгийн Хутаг-Өндөр сумын харьяат О.Намхай үзүүрлэж, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын харьяат Т.Оргилболд түрүүлж өнгөтэй сайхан наадлаа.

БИДНИЙ ДАРХАН 2019" АРГА ХЭМЖЭЭНД НЭГДЭН ӨГЛӨӨНИЙ ДАСГАЛ ХИЙВ

Монгол Улсын хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас "Бидний Дархан-2019" арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөжээ. Тус аяны хүрээнд томоохон аж ахуй нэгж байгууллагуудад, ажил эхлэхийн өмнө биеийн тамирын дасгал тогтмол хийж хэвшүүлэх үүднээс өнөөдөр / 2019.08.30/-ны өдөр Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн ажилтнууд өглөөний дасгалд хамрагдсан



байна. Эрүүл амьдралын хэв маяг, идэвхтэй дасгал хөдөлгөөн буюу эрүүл мэндийн зөв дадал гэдгийг өглөөний дасгалын үеэр Шинобу фитнес клубын багш Г.Галбадрах онцлон хэлж байлаа.

АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

НҮБ-ын ерөнхий асамблей 1992 оноос эхэлж жил бүрий 10 дугаар сарын 1-ний өдрийг олон улсын ахмадын баяр болгон тэмдэглэхийг дэлхий даяар албан ёсоор тунхагласаны дагуу манай улс 1992 оноос эхлэн ахмадын баярыг тэмдэглэсээр даруй 27 жил болсон байна. Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн хамт олон жилд 2 удаа ахмад буурлуулаа хүлээн авч хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай.

Үйл ажиллагааг нээж компанийн Дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Батжаргал хэлсэн үгэндээ өнгөрсөн хугацаанд эрчим хүчний салбарт хийж гүйцэтгэсэн онцлог үйл ажиллагаа, цаашид хийгдэх гол ажлыг товч танилцуулан, ахмад буурлуудаа үргэлж өнөөдрийнх шиг баяр баясгалантай байж, хэний ч өмнө өөрсдийн хийж бүтээсэн зүйлээрээ, ажиллаж байсан байгууллагаараа бахархан, үргэлж үлгэр дууриал болж, эрүүл энх, урт удаан наслахыг хүсэн ерөөлөө.



ENERGY LEAGUE-2019 ЭХЭЛЛЭЭ



ДСЦТС ХК-ийн Энержи лиг-2019 сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн өнгөрсөн амралтын өдөр Эрчим спортын ордонд эхэллээ. Эрэгтэй 8 эмэгтэй 4 багийн нийт 150 гаруй тамирчид тус тэмцээнд оролцож байна. Лигийн тэмцээн 2019.12.06-ны өдөр хүртэл үргэлжлэх бөгөөд сар гарангийн хугацаанд компанийн ажилтнууд тогтмол дасгал хөдөлгөөн хийж тэмцээндээ оролцсоноор ажилтнуудын бие бялдрын хөгжил сайжирч спортын идэвхи дээшлэх юм.

6.2.Хэвлэл мэдээллийн чиглэлээр

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК пэйж хуудсанд цаг үеийн бүх мэдээнүүд тогтмол тавигдаж байна. Мөн ТӨЛӨВЛӨГӨӨТ ТАСЛАЛТЫН мэдээлэл өдөр тутам цахим хуудас болон сошиал медиагийн олон гишүүнтэй хуудсуудад тавигдаж байгаа нь иргэдийн талархлыг хүлээж байна.

2019 онд пэйж хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийтдээ 154 төрлийн сэрэмжлүүлэх мэдээлэх, төрлийн мэдээ мэдээлэл постууд тавигдсан байна.

2018.04.10 –наас эхлэн Орон нутгийн DBS телевизтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд үйл явдлын мэдээлэл, ярилцлага, ажлын байрны нээлттэй зар, сэрэмжлүүлэг зэрэг мэдээллүүд тус телевизээр цацагдаж байна. Мөн ЛХА, RGB, SBN UBS МҮОНТВ зэрэг телевизүүдэд мэдээлэл ярилцлага өгч хамтран ажиллалаа. Дүрстэй мэдээ 7 өгч, 3 удаагийн ярилцлаганд орлоо.

Мон студитэй видео чиглэлийн



ажлаар хамтран ажиллаж байна. Компанийн сайт ашиглалтанд орж мэдээлэл ярилцлага тавигдаж байна. Тэмдэглэлт үйл ажиллагааны мэндчилгээ, хэрэглэгчид рүү чиглэсэн мэдээллийн постерууд хийгдсэн байна.

6.3 Шүүхэд хэрэг төлөөлөх

Шүүхэд хэрэг төлөөлөх үндсэн чиг үүргийн хүрээнд цахилгаан эрчим хүчний төлбөрийн өртэй, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй аж ахуй нэгж иргэнийг шүүхэд шилжүүлэн шүүхийн шийдвэр гаргуулан, шүүхийн шийдвэр биелүүлэхгүй буй аж ахуй нэгж, иргэнийг ШШГА-нд өгч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлж ажиллалаа.

Цахилгаан эрчим хүч хангах гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй, цахилгаан эрчим хүчний төлбөрөө төлж барагдуулаагүй 29 аж ахуй нэгж, иргэнийг харъяаллын дагуу Улаанбаатар хот, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган улмаар шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон болно.

Дээрх өр төлбөртэй 29 аж ахуй нэгжээс 2 104 119 864 төгрөг гаргуулах хэрэг маргааныг 100 хувь ДСЦТСүлжээ ХК-ийн талд гаргуулж ажиллав. Түүнчлэн “Эрчим хүчний тухайн хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу түүнд ногдох алдангиас огт чөлөөлөхгүйгээр шүүхийн шийдвэрийг гаргуулж ажиллав.

Шүүхийн шийдвэр гарсан 29 аж ахуй нэгжийн 2 104 119 864 төгрөгөөс:

- a. Өр төлбөрөө барагдуулж дууссан -15 ААН /118 405 730 төгрөг/
- b. Хэсэгчлэн төлбөрийг барагдуулсан 10 ААН / 498 727 705 төгрөг/
- c. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд ажиллагаа хийгдэж буй- 9 ААН / 1 820 785 440 төгрөг/
- d. Төлбөр төлөх хугацаа болоогүй- 5 ААН / 164 928 694 төгрөг

Төлбөрийн барагдуулалтыг графикаар харуулбал :



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ӨР ТӨЛБӨР БАРАГДУУЛЖ ДУУССАН
АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Нийт дүн /Төгрөг/	Нэхэмжилсэн үнийн дүн	Алданги	Тайлбар
1	Шинэ өргөө СӨХ	391,453.0	391,453.0	-	2019.01.27-ны өдөр дууссан
2	Барилга тех ХХК	1,486,275.0	1,292,415.0	193,860.0	2019.01.29-ний өдөр дууссан
3	Антрацит ХХК	4,546,315.0	3,956,335.0	589,980.0	2019.01.30-ны өдөр дууссан
4	Бат арвижих СӨХ	597,721.0	597,721.0	-	2019.02.28-ны өдөр дууссан
5	Говь хангай өрөм ХХК	31,134,579.0	27,073,569.0	4,061,010.0	2019.03.06-ны өдөр дууссан
6	Рич мөнх ХХК	24,119,530	20,973,520	3,146,010	2019.04.25 ны өдөр дууссан
7	Гэрэлт цамхаг СӨХ	1,185,000	1,185,000	-	2019.05.01-ний өдөр дууссан
8	Спорт цогцолбор Мөнхнайрамдал	1,260,000	1,260,000	-	2019.05.01-ний өдөр дууссан
9	А.Баярзул	599,989	599,989	-	2019.05.09-ний өдөр дууссан
10	Саруул Сөх	703,616	703,616	-	2019.05.09-ний өдөр дууссан
11	Платиниумланд ХХК	39,562,438	34,402,138	5,160,300	2019.05.15 ний өдөр дууссан
12	Сэлэнгэ шим ХХК	10,368,872.0	10,368,872.0	-	2019.08.19-ний өдөр дууссан /Трансформатор/
13	Гурван эрдэнэ цемент ХХК	887,517	726,287	161,230	2019.09.09-ний өдөр дууссан
14	Н.Батмөнх	1,262,440	1,182,440	80,000	2019.09.20-ны өдөр дууссан
15	Жавхлант СӨХ	299,985	299,985	-	2019.10.01-ний өдөр дууссан
	Нийт	118,405,730	105,013,340	13,392,390	

1. Хөтөл цемент шохой ХК –иас 2 892 250 950 төгрөг гаргуулахаар 2016 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 310 дугаартай шүүгчийн захирамж гарсан бөгөөд дээрх захирамжийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт тавьж шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай зардлын гэрээ байгуулсан боловч захирамж гарсан хугацаанаас төлбөр төлөгдсөнд тооцогдож 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдөр гүйцэтгэх хуудас хаагдсан болно.

2. Сэлэнгэ энерго ХХК-иас 339 195 062 төгрөг гаргуулахаар 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 353 тоот шүүгчийн захирамж гарсан. Дээрх төлбөрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт тавьж шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай зардлын гэрээ байгуулсан боловч захирамж гарсан хугацаанаас төлбөр төлөгдсөнд тооцогдож 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр гүйцэтгэх хуудас хаагдсан болно.

Дээрх 2 аж ахуй нэгжийн гэрээг шинэчлэн дахин шинээр материал бүрдүүлж шүүхэд нэхэмжлэл гаргасан болно.


ШШГА-Д АЖИЛЛАГАА ХИЙГДЭЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖҮҮД:

Шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг маргаанаас шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй, өр төлбөрөө төлж барагдуулаагүй аж ахуй нэгжийг шүүгчийн захирамжаар албадан гүйцэтгэх хуудас гаргуулж шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд зардлын гэрээ байгуулж албадан гүйцэтгэх ажиллагаа явууллаа.

Шүүхийн шийдвэр гарч ШШГА албадан гүйцэтгэх ажиллагаа хийгдэж буй ахуй нэгжийн жагсаалт

ШШГГ-Т ЗАРДЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН АЖ АХУЙ НЭГЖИЙН ЖАГСААЛТ						
№	Байгууллагын нэр	Нийт дүн /Төгрөг/	Төлсөн төлбөрийн дүн	Үлдэгдэл	ШШГА-д зардлын гэрээн байгуулсан огноо	Тайлбар
1	Хараа СӨХ	1,588,752	528,535	1,060,217	2019.01.27	Данс хаалттай
2	Батбродэрс майнинг ХХК	823,384,933	198,284,933	625,100,000	2019.01.30	ШШГА түр зогсоосноос өр өссөн
3	"Дулаан Шарын гол" ТӨХК	545,699,714	47,799,714	497,900,000	2019.02.13	Данс хаалттай
4	"Дархан Ус суваг" ХК	410,393,119	235,193,119	175,200,000	2019.02.13	Данс хаалттай
5	Давшилт 21 СӨХ	1,450,305	-	1,450,305	2019.02.29	Гүйцэтгэх захирал солигдсон
6	Арван дөрөв СӨХ	911,376	124,893	786,483	2019.02.29	Гүйцэтгэх захирал солигдсон
7	Тэдэ констракшн ХХК	10,555,635	3,998,000	6,557,635	2019.05.24	Энэ онд дуусгах баталгаа гаргасан
8	Захирагчийн алба	20,000,000	-	20,000,000	2019.09.07	Хугацаатай үүрэг өгсөн
9	Монбамбай ХХК	6,801,606	Граж өгөх	6,801,606	2019.10.04	Хугацаатай үүрэг өгсөн
Нийт		1 820 785 440	485 929 194	1 334 856 246		

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэж буй өр төлбөртэй аж ахуй нэгжийн өр төлбөр барагдсан байдлыг харуулвал :



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГАРСАН БӨГӨӨД ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ХУГАЦАА АЖ АХУЙ НЭГЖ					
№	Байгууллагын нэр	Нийт дүн /Төгрөг/	Төлсөн төлбөрийн дүн	Үлдэгдэл	Тайлбар
1	Дорнын зам ХХК	8,533,568	1,500,000	7,033,568	2019.11.25-ны өдөр дуусна
2	Эрдэнэс Майинг ХХК	37,833,190	-	37,833,190	Албадан гүйцэтгүүлэх хүсэлт авахаар шүүхэд хандсан
3	Урсгал ус ХХК	116,497,593	10,000,000	106,497,593	2020.01.20-ний өдөр дуусна
4	Идэр СӨХ	798,797	598,511	200,286	2020.02.16-ны өдөр дуусна
5	Саруул СӨХ	1,265,546	700,000	565,546	2020.03.16-ны өдөр дуусна
Нийт		164,928,694	12,798,511	152,130,183	

ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖААР ХЭРГИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОЖ БУЦААСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРҮҮД

“Их орд эко лайн” ХХК-аас цахилгаан эрчим хүчний төлбөр 11.606.598 төгрөгийг гаргуулахаар Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч шүүгчийн захирамжаар тус байгууллага нь үйл ажиллагаа явуулахгүй, нэхэмжилсэн хаяганд бүртгэлгүй, хаяг тодорхойгүй шалтгаанаар хэргийг хэрэгсэхгүй болгосон

ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ХҮЛЭЭГДЭЖ БУЙ АЖ АХУЙ НЭГЖИЙН НЭХЭМЖЛЭЛИЙН ЖАГСААЛТ:

Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх

1.Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-аас цахилгаан эрчим хүч хэрэглэсэн төлбөр болох 507,278,266 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх

2.Хөтөл цемент шохой ХК-иас цахилгаан эрчим хүч хэрэглэсэн төлбөр болох 816,622,863 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн ИХАШШүүх

3.ЧЧБТ ХХК-иас цахилгаан эрчим хүч хэрэглэсэн төлбөр болох 32,353,484 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан болно.

Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх / Зөрчлийн акт/

4.Дархан хотын бохир усны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажлыг гүйцэтгэж буй “Цагаан зуун” ХХК нь 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 110/6кВ Бурхант д/ст яч№12-с РП-3 яч№10 кабель шугамыг эксковатор газар шорооны ажил хийх үедээ тасалсан болно. Зөрчлийг судалсан актаар тогтоосон 23 679 087 төгрөгийн төлбөрийг гаргуулах шүүх хурал хариуцагчийн хүсэлтээр шинжээчийн дүгнэлт гаргуулахаар хэрэг түр хугацаанд түтгэлзсэн болно.

Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх

5.Дархан Моунтайнс ХХК-иас цахилгаан эрчим хүч хэрэглэсэн төлбөр болох 625,865 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан болно. Шүүх хурал товлогдоогүй болно.

Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх /Зөрчлийн акт/

6.Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын иргэн Д.Сарантуяа хашааныхаа хог шатааж цэвэрлэх үеэр малын саравч өвөлжөө нь шатаж улмаар Дархан Түгээх төв Хүдэр хэсэг АТП136 Д/СТ 1 дүгээр гаргалгааны агаарын шугамны сип утас гэмтсэн. Агаарын шугам шатаж гэмтсэн зөрчлийг судалсан актаар тогтоосон 3 414 682 / гурван сая дөрвөн зуун арван дөрвөн мянга зургаан зуун наян хоёр төгрөг/-ийн төлбөрийг гаргуулахаар нэхэмжлэл өгч, шүүх хурал товлогдоогүй байна.

6.4. Гэрээ, Журмын төсөл боловсруулах, баталгаажуулах, хяналт тавих

2019 онд аж ахуй нэгж, иргэн хуулийн этгээдтэй 214 гэрээ байгуулан, гэрээний төсөл боловсруулж, хяналт тавин гүйцэтгэх удирдлагаар баталгаажуулан ажиллаж байна.

Нийт байгуулагдсан гэрээнээс хугацаа хэтэрсэн, гэрээний үүргээ биелүүлээгүй гэрээ байхгүй.

Тайлант хугацаанд байгуулсан 214 гэрээ нь дараах нэрлэсэн гэрээний эрх зүйд хамрагдаж байна. Үүнд:

1. Бараа материал худалдан авах гэрээ - 38
2. Авто машин түрээслэх гэрээ – 44
3. Хамтран ажиллах гэрээ – 39

4. Орон сууц худалдах, худалдан авах гэрээ-37
5. Ажил гүйцэтгэх гэрээ- 41
6. Үйлчилгээ-8
7. Бусад гэрээ – 7 гэсэн чиглэлээр гэрээнүүд байгуулагдсан байна.


Хэрэглэгч, иргэн аж ахуй нэгжтэй шуурхай ажиллагааны гэрээ байгуулах

ДСЦТС ХК нь аж ахуй нэгж, иргэн хуулийн этгээдтэй 18 гэрээ байгуулан техникийн үед мөрдөх дүрэм заавар эрх үүргийг тодруулж, шуурхай ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

Эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан эрчим хүч хангагч хэрэглэгчийн гэрээ байгуулах заалтууд, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг зөрчиж цахилгаан эрчим хүчээр хангаж хэрэглэгчийг тэжээж буй зөрчил дутагдлыг арилгах, гэрээний нэмэлт баяжилтыг тогтмол чанартай хийх, зэрэг ажлуудад дээр анхаарч ажиллах шаардлагатай байна

ТЕХНОЛОГИЙН ЗӨРЧЛИЙГ СУДАЛСАН ТАЛААР

Технологийн зөрчлийг судлан бүртгэх комисст удаа ажиллан зөрчил гаргасан иргэн аж ахуй нэгжээс учруулсан хохиролыг нөхөн төлүүлж ажиллав. Эрчим хүчний тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөх заалтыг тайлбарлаж өгөх, ДСЦТС ХК-нд учирсан хохирлыг бүрэн барагдуулахаа илэрхийлсэн гар өргөгдлийг бичүүлж авч байна.



Тус хугацаанд 26 удаагийн технологийн зөрчлийг судлан бүртгэх комисст орж ажиллав. Үүнээс ДСЦТС ХК-ийн эзэмшлийн шугам тоноглолыг бусдын болгоомжгүй үйлдлээс 22 удаагийн Технологийн зөрчил гарч 51 549 334.33 төгрөгийн хохирол учирсан байна. Үүнээс 15 339 209.33 төгрөгийг барагдуулан ажиллалаа.

№	Зөрчлийн ангилал	Технологийн зөрчлийн тоо	Нийт хохирол /мян.төг/	Төлөгдсөн дүн /мян.төг/
1	Гадны хүний буруугаас	22	51549334.33	15339209.23
	Дүн	22	51.549.334.33	15.339.209.23

Технологийн зөрчлийг салбар, нэгжээр нь харуулбал:

№	Салбар нэгж	Технологийн зөрчлийн тоо	Нийт хохирол /төг/	Төлөгдсөн дүн /төг/
1	Сүхбаатар салбар	6	11373799.7	8602372.7
2	Хөтөл	2	1429616.45	1429616.45
3	Дархан түгээх төв	5	6358496.68	2505002.88
4	ЗТТАлба	7	30867024.17	2077687.2
5	Шарын Гол	1	724530	724530
6	Зүүнхараа	1	795867.327	0
	Дүн	22	51549334.33	15339209.23

6.5. Бичиг баримтыг бүртгэх, боловсруулах талаар

➤ 2019 онд Захиргаа удирдлагын хэлтэст салбар, нэгж, ажилтнуудаас нийт 214 албан хүсэлт, өргөдөл ирснийг бүртгэн авч, шинээр ажилд орох хүсэлт ирүүлсэн 103 хүнийг нөөцөд бүртгэн, Захирлын зөвлөлийн хурлаар оруулан шийдвэрлүүлж 28 хүнийг нь ажлын байраар ханган, зохих журмын дагуу тушаал, шийдвэрийг гаргуулан хугацаанд нь хариу мэдэгдсэн байна.

➤ Өргөдөл, албан хүсэлт, бусад цаг үеийн асуудлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 457 тушаалыг боловсруулан, хянуулан баталгаажуулж, холбогдох салбар, нэгжүүдэд цахим болон цаасан хэлбэрээр явууллаа.

➤ Баримт бичгийн нэгдсэн жагсаалт буюу 2020 оны ХХНЖ-ийг боловсруулж байна.

➤ Нийт ажилтнуудын хувийн хэргийг коджуулж, товъёог үйлдэн баримт бичгийн бүрдлээр баяжилтийг хийлээ.

➤ Ажилтнуудын ажилласан жилийг үндэслэн тушаалд 405 ажилтны ээлжийн амралтын хоног, 84 ажилтны удаан жилийн нэмэгдлийг тооцоолон гаргах, 98 ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалтын хуудсанд улсад ажилласан жилийн тэмдэглэгээ, бүртгэлийг хийж Санхүү эдийн засгийн хэлтэст гаргаж өгсөн..

Хүний нөөцийн бодлогын бичиг баримтыг боловсруулах талаар

➤ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын хэсгийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 5/103 тоот албан бичгээр ирсэн шаардлага, зөвлөмж, Эрчим хүчний салбарын Хүний нөөцийн бодлого, мөн “Дархан-Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн хүний нөөц буюу боловсон хүчний урт болон

богино хугацааны баримталж буй бодлогод үндэслэн компанийн хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, сургаж хөгжүүлэх, тогтоон барих, ажилтны манлайллыг бий болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтныг урамшуулан шагнах, судалгаа шинжилгээ хийх, нийгмийн баталгааг хангах зэрэг замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгох бодлогын хүрээнд “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг” боловсруулах ажил эцсийн шатандаа явж байгаа болно.

➤ Албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн “Able” програмд Гүйцэтгэх захирлын 2019 оны 04 дүгээр тушаалаар комисс томилон компанийн ажилтнуудын анкет мэдээлэл, бусад баримт бичгийн бүртгэлийг оруулан зарим судалгаа, тайланг гарган авч ажиллаж байна.

Архивын бичиг баримтын хадгалалт, ашиглалтын талаар

➤ Архивын заавар, Баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтыг үндэслэн хадгаламжийн нэгжийг он, ач холбогдол, хэрэг бүрдүүлсэн салбар, нэгж тус бүрээр ялгаж жагсаан, бүртгэл үйлдэн хадгалж, холбогдох ажилтнуудад ашиглуулж байна.

➤ Гүйцэтгэх захирлын 2018 оны 05 дугаарын сарын 10-ны өдрийн 510 дугаар тушаалаар батлагдсан “Архивын журам”-ын дагуу компанийн болон салбар нэгжийн архивын баримт бичгийг эмхлэн цэгцэлж, заавар зөвлөмжийг өглөө.

➤ Байгууллагын архиваас 23 хүнд тушаалын хуулбар, 6 ажилтанд хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийг тодорхойлсон албан бичиг, 9 ажилтанд цалингийн тодорхойлолтыг тус тус гаргаж өглөө.

➤ Компанид мөрдөгдөж байгаа баримт бичгийн “Бүртгэлийн нэгдсэн жагсаалт”-ын дагуу 2020 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг боловсруулж байна.

➤ Компанийн ажилтнуудын ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах ажлын хүрээнд Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажлын байрны өрөө, тасалгаа, баримт бичгийг хаягжуулан эмхлэн цэгцлэв.

6.6. Сургалт хөгжлийн талаар

2019 онд төлөвлөгдсөн сургалтуудад төлөвлөгөөний дагуу ажилтнуудыг хамруулсан.

2019 оны батлагдсан сургалтын ажлын төлөвлөгөөнд 46 чиглэлээр сургалт явуулахаар төлөвлөснөөс 44 чиглэлээр давхардсан тоогоор 1177 ажилтанд сургалтыг зохион байгуулж, сургалтын гүйцэтгэл 95%-тай байна. Үүнээс:

Компанийн хэмжээнд дотооддоо 17 чиглэлээр давхардсан тоогоор 944 ажилтан, мэргэшүүлэх чиглэлээр 21 сургалтыг 189 ажилтанд, гадаадад 6 чиглэлээр 6 ажилтныг сургалтанд тус тус хамруулсан.

35/10кВ-ын Сургалт дэд станц дээр хийгдэх сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулан мөрдөж ажиллаж байна.

"ДСЦТС" ХК-ИЙН СУРГАЛТЫН ПОЛИГОН ДЭЭР ХИЙГДЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Д/д	Сэдэв	Агуулга	"ДСЦТС" ХК-аас
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр авах арга хэмжээ	Зааварчилгааны төрлүүд, аюулгүй ажиллагааны санамж, хамгаалах хэрэгсэл, галын булан	ХАБЭАИ Т.Мөнх-Оргил
2	Цахилгаан түгээх сүлжээний схемийн бүтэц	Зарчмын схем	ТБТХэлтсийн Засвар шинэчлэлийн инженер Б.Болдсүх
3	35/10кВ-ын дэд станцын цахилгаан схемтэй танилцах	Схемийн төрлүүд	
4	35кВ-ын ил хуваарилах байгууламжийн тоноглолын бүтэц, ажиллах зарчим, угсралт	С-35 тосон таслуур, гүйдлийн трансформатор, GWD1-630 хуурай салгуур JDJJ2 хүчдэлийн трансформатор, ОПН хэт хүчдэл хязгаарлагч, АС-95 зөөлөн шин	
5	35кВ-ын хуваарилах байгууламжийн реле хамгаалалт хэмжүүрийн хэлхээний схем, холболт, ажиллах зарчим	Гүйдлийн хамгаалалт, Тоолуур	РХА инженер Л.Баярсайхан
6	35/10кВ-ын хүчний трансформаторын бүтэц, ажиллах зарчим, угсралт, ашиглалт, засвар	ТМ-400, хөргөлтийн систем, оруулга, хийн реле, тос зайлуулах систем	ТЗИ П.Төмөрчөдөр
7	10кВ-ын хуваарилах байгууламжийн анхдагч хэлхээний холболт, тоноглолын бүтэц, ажиллах зарчим	ВК-10 тосон таслуур, ТПЛ-10 гүйдлийн трансформатор, НТМИ-10 хүчдэлийн трансформатор	Дэд станцын инженер Б.Өнөрбат
8	10кВ-ын хуваарилах байгууламжийн реле хамгаалалт хэмжүүрийн хэлхээний схем, холболт, ажиллах зарчим	МТО, МТЗ хамгаалалтын ажиллах зарчим, Цахилгаан механик релений бүтэц, тоолуур хэмжүүрийн хэлхээ	РХА инженер Л.Баярсайхан
9	10кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамын хийц, эд ангиудыг судлах	УКШ маягийн завсрын болон анкер тулгуур, ПС-70, Р-15 тусгаарлагч, АС-50 дамжуулагч утас, траверс, шувуу үргээгч, газардуулга, угсралт	ТБТХэлтсийн АЗИ Д.Батсайхан
10	10кВ-ын Цахилгаан дамжуулах кабель шугамын хийц, эд ангиудыг судлах	АБЛУ-3х120мм ² кабель, төгсгөлийн муфть, төгсгөвч	
11	10/0.4кВ-ын агаарын дэд станцын цахилгаан схем, хийц, тоноглолтой танилцах	Хийц, хуурай салгуур, цэнэг шавхагч, гал хамгаалагч, трансформатор, 0.4кВ-ын хуваарилах самбар, гар салгуур, газардуулга	ДТТөвийн Мастер Х.Түвшинжаргал

12	10/0.4кВ-ын иж бүрэн дэд станцын цахилгаан схем, хийц, тоноглолтой танилцах	Хийц, хуурай салгуур, цэнэг шавхагч, гал хамгаалагч, трансформатор, 0.4кВ-ын хуваарилах самбар, гар салгуур, газардуулга	
13	0.4кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамын хийц, эд ангиудыг судлах	УКШ маягийн завсрын болон анкер тулгуур, СИП-2А дамжуулагч утас, шугамын арматур /РА-1500, GXGF3, TTD101, 151, 181/, Тоолуурын хайрцаг, газардуулга, ухаалаг тоолуур, угсралт	ЗШИ Б.Болдсүх
14	10кВ-ын кабель шугамын хөндийрүүлэг хэмжих	Мегаомметрээр	Туршилтын инженер В.Наранбаатар
15	Дэд станцуудын газардуулгын эсэргүүцэл хэмжих	М-416 багаж ашиглах	
16	35/10кВ-ын сургалт дэд станц, АТП-192, КТП-242 дэд станцад хийгдэх сэлгэн залгалтууд	Ажлын байр бэлтгэх, сэлгэн залгалтын програм бичих, сэлгэн залгалт хийх,	ШҮМАлбаны дарга Ж.Ариунаа

Энэхүү сургалтын хөтөлбөрийн дагуу ШУТИС-ийн ДаТС-ийн цахилгаан системийн 2-р ангийн 32 оюутанд манай ИТА нар 2019.06.03-2019.06.21 өдрүүдэд сургалт зохион байгуулсан.

6.7. Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд

- Компанийн захиргаа, ҮЭ-ийн хороотой 2017 онд байгуулсан 74 зүйлтэй Хамтын гэрээний хэрэгжилтийн ханган ажиллаж байна.
- 80 ажилтан, 59 ахмадад салбарын болон бусад салбарын тэргүүний ажилтаны нэмэгдлийг сар бүр олгож байна.
- 54 ажилтны удаан жилийн нэмэгдлийн өөрчлөлтийг сар бүр тушаалаар баталгаажуулан олголоо.
- 402 ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулан, мөн эмчилгээ, сувиллын хөнгөлөлтөнд 12,6 сая төгрөг зарцууллаа.
- Сар шинийн баярыг тохиолдуулан ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн хүлээн авч 6,3 сая төгрөг, 112 ахмад болон групптэй хүмүүст буцалтгүй тэтгэмжид 4,5 сая төгрөг зарцууллаа.
- Хамтын гэрээний дагуу хүүхэд төрүүлсэн 4 ажилтанд 600,0 мянган төгрөгийн тэтгэмжийг олголоо.
- Өндөр насны тэтгэвэрт гарсан 6 ажилтанд 1 удаагийн буцалтгүй тэтгэмж 41,3 сая төгрөг олгосон.
- Мөн 1 удаагийн буцалтгүй тусламжийг 10 ажилтанд 5,1 сая төгрөгийг, 5 ахмадад 750,0 мянган төгрөгийг тус тус олгосон.
- Компанийн дотоод журмын дагуу 19 ажилтанд цалинтай чөлөө, 7 ажилтанд цалингүй чөлөөг тус тус олгов.
- Компанийн хөрөнгөөр 48 айлын орон сууцыг ашиглалтад оруулан ажилтнуудаа оруулсан.

Долоо. Шинэ санал, санаачлага

Судалгаа тооцоо хийхэд тус программын мэдээллийг үндэслэн тайлан мэдээ тооцоо хийхэд бодит, хялбар болно. Эхний ээлжинд тус программ хангамжийн Standart хувилбарыг худалдан авч мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна.


Одоогийн байдлаар нийт Дархан болон Сэлэнгийн төвийн хэсгийн 202 дэд станц болон Жимс, болон хонгор 35кВ-ын ЦДАШ-ын мэдээллийг оруулж байна.

2019 оны 9-р сард тус пограмм хангамжийг худалдан авч анхан шатны сургалтанд хамрагдсан. 10-р сараас эхлэн мэдээллийн сан, бааз бүрдүүлэх ажлыг эхлүүлж Дархан-Уул аймаг Дархан сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хэсгийн дэд станцуудын байршил, 35 кВ-ын ЦДАШ-ын атрибутан мэдээллийг оруулж бааз бүрдүүлэх ажлыг хийн, цаашид тус программ хангамжийн баяжилтын ажлын 2020 оны төлөвлөгөө гарган батлуулж ажиллаж байна.


БАТЛАВ. ДСЦТС ХК-НЫ ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР.....Б.БАТЖАРГАЛ

ARCGIS ПРОГРАММЫН БААЗ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН КАЛЪЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нэгж салбар	Ажлын нэр	Гүйцэтгэх ажилтан	Хугацаа		Биелэлтийн хувь	Тайлбар
				Эхлэх	Дуусах		
1	ДТТөв	Дэд станц	ТБТХ-ын ЗТТТ О.Ууганбаатар	2019.09.15	2019.12.31		
2		35 кВ-ын ЦДАШ		2019.11.4	2019.12.31		
3		6/10 кВ-ын ЦДАШ		2019.11.04	2019.12.31		
4		0.4 кВ-ын ЦДАШ		2020.01.01	2020.06.01		
5		6/10кВ-ын КШ		2020.05.01	2020.09.01		
6		0.4кВ-ын КШ		2020.05.01	2020.09.01		
7	Сүхбаатар	Дэд станц		2019.11.15	2019.12.31		
8		35 кВ-ын ЦДАШ		2019.11.15	2019.12.31		
9		6/10 кВ-ын ЦДАШ		2019.11.01	2019.12.31		
10		0.4 кВ-ын ЦДАШ		2020.03.01	2020.04.15		
11		6/10кВ-ын КШ		2020.03.02	2020.04.16		
12	0.4кВ-ын КШ	2020.03.03		2020.04.17			
13	Зүүнхараа	Дэд станц		2020.06.01	2020.07.01		
14		35 кВ-ын ЦДАШ		2020.06.30	2020.07.30		
15		6/10 кВ-ын ЦДАШ		2020.06.01	2020.04.20		
16		0.4 кВ-ын ЦДАШ		2020.07.01	2020.08.01		
17		6/10кВ-ын КШ		2020.07.01	2020.08.01		
18	0.4кВ-ын КШ	2020.07.01		2020.08.15			
19	Хөтөл	Дэд станц		2020.06.01	2020.10.30		
20		35 кВ-ын ЦДАШ		2020.06.15	2020.10.30		
21		6/10 кВ-ын ЦДАШ		2020.06.20	2020.10.30		
22		0.4 кВ-ын ЦДАШ		2020.06.08	2020.12.01		
23		6/10кВ-ын КШ		2020.06.15	2020.12.01		
24	0.4кВ-ын КШ	2020.06.22		2020.12.01			
25	Жаргалант	Дэд станц		2020.05.01	2020.06.01		
26		35 кВ-ын ЦДАШ		2020.05.01	2020.06.01		
27		6/10 кВ-ын ЦДАШ		2020.10.19	2020.12.01		
28		0.4 кВ-ын ЦДАШ		2020.11.01	2020.12.01		
30		0.4кВ-ын КШ		2020.11.01	2020.12.01		



АrcGis Программын бааз бүрдүүлэх атрибутан мэдээлэл оруулах ажил



ArcGis Программын бааз бүрдүүлэх атрибутан мэдээлэл оруулах ажил

Станцын атрибутан мэдээлэл

Станцын төрөл	Станцын нэр, дугаар	Трансформаторын тоо	Трансформаторын чадал Т-1 [кВА]
Дэд өртөө	ТП-504	2 ш	400
Дэд өртөө	ТП-70	2 ш	400
Дэд өртөө	<Null>	2 ш	<Null>
<Null>	<Null>	<Null>	<Null>
<Null>	<Null>	<Null>	<Null>
<Null>	<Null>	<Null>	<Null>
<Null>	<Null>	<Null>	<Null>
<Null>	<Null>	<Null>	<Null>
<Null>	<Null>	<Null>	<Null>

Аттрибутан мэдээллийн хүснэгт

Feature Class Properties

General Editor Tracking XY Coordinate System Domain, Resolution and Tolerance
Fields Indexes Subtypes Feature Extent Relationships Representations

Field Name	Data Type
OBJECTID	Object ID
SHAPE	Geometry
Substation_type	Short Integer
Substation_name_number	Text
Transformer_number	Short Integer
Transformer_power_1	Long Integer
Transformer_power_2	Long Integer
Second_type	Short Integer
Voltage_level	Short Integer
Obektiin_code	Long Integer
Owner	Short Integer
Ashiglagch_baiguullaga	Text
Hariutsah_negj	Short Integer

Click any field to see its properties.

Field Properties


Alias	OBJECTID
-------	----------

Import...



To add a new field, type the name into an empty row in the Field Name column, click in the Data Type column to choose the data type, then edit the Field Properties.

OK Cancel Apply

Аттрибут мэдээллийг хийх хүснэгт



Автокад дээрх станцын цэг



ArcGis Программын бааз бүрдүүлэх атрибутан мэдээлэл оруулах ажил



Найм. Дүгнэлт

Хангах үйл ажиллагааны дүгнэлт:

ЦЭХ-ний худалдан авалт 33,3 сая кВт цагаар буюу 7.5 хувиар өссөн.

ЦЭХ-ний борлуулалтын төлөвлөгөө 104,3 хувиар биелсэн

Түгээлтийн алдагдал 10,11% болж 3,79 нэгжээр буурсан

ЦЭХ-ний орлогын төлөвлөгөө 102.2 хувиар биелсэн.

ЦЭХ-ний авлага 2,3 тэрбум төгрөг болж оны эхнээс 0,16 тэрбум төгрөгөөр буюу 7,1 хувиар буурсан.

Түгээх үйл ажиллагааны дүгнэлт:

Их засвар, ТЗБАХ, ХО-ын ажил- 62 ажлыг 6.2 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 6,2 тэрбум төгрөгөөр 62 ажлыг хийж 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Урсгал засвар- 337 ажлыг 1,26 тэрбум төгрөгөөр хийхээр төлөвлөснөөс 337 ажлыг 1,537 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэл 100%-тай байна.

Эргүүл үзлэг- 8806 цэгт эргүүл үзлэг хийхээс 8806 цэгт хийж 100% гүйцэтгэлтэй байна. Үзлэгүүд төлөвлөгдсөн хугацаандаа бүрэн хийгдэж байна.

Дуудлага барагдуулалт- 2019 онд ахуйн 37011, ААН 496, дэд станц хуваарилах байгууламжийн 490 нийт 37997 дуудлага ирснийг барагдуулсан байна. Нийт дуудлагын хэмжээнд борлуулалтын дуудлага 20014 буюу 52.6%, ашиглалтын дуудлага 17983 буюу 47.4%-ийг эзлэж байна. Дуудлагын тоо өмнөх оны энэ үетэй харьцуулахад 2995 буюу 8,5%-иар өссөн мөн дуудлагын дундаж хугацаа 10.2 минут буюу 0.17 цагаар буурч хэрэглэгчдэд чанартай хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Тасралт- 2019 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд 386 удаа тасралт гарсан бол тасралтын дундаж хугацаа 4.02 цаг, ДТЭХ 136 086 кВт*цаг байгаа нь 2018 оны мөн үетэй харьцуулахад тасралт 66 тасралт буюу 14.7%, дундаж хугацаа 1.74 цаг буюу 30.3%, ДТЭХ 8798 кВт*цаг буюу 6.1%-иар тус тус буурсан байна.

Ашиглалтын түвшин- Салбар, алба, төвүүдийн дэд станцын ашиглалтын түвшин жил ирэх тусам дээшилж байна. 2018 оны ашиглалтын түвшин 87.7% байсан бол 2019 онд ашиглалтын түвшин 89.1% болж 1.4%-иар өссөн.

Ажлын зураг- Зургийн ажлын 2019 оны эхний 11-р сарын байдлаар нийт 71,8 км 0,4 кВ-ын АШ, 6(10)кВ-ын 14 дэд станц, 6(10)кВ-ын ЦДАШ 7.5 км ЦДАШ, 35кВ-ын ЦДАШ-ын 8,7км, нийт 88км урт шугамын ажлын зургийг хийж гүйцэтгэсэн.

Баланс тооцоо- 2019 онд ХАЦ-ын програм авснаар баланс тооцоог хүний оролцоогүйгээр автоматаар хийдэг болсон.

ХАБЭА-н үйл ажиллагааны дүгнэлт:

ХАБЭА- Ажлын байрны гэнэтийн үзлэг, аюулгүй ажиллагааны дүрмийн мөрдөлт, нарядын системийн мөрдөлт, хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасыг хэрэглэж хэвшсэн байдал, ажлын байрны сахилга дэг журмын мөрдөлт зэрэгт ХАБЭА-н хяналтын үзлэгийг зохион байгуулан ажиллаж байна.

Нэгдсэн удирдлагын тогтолцооны хүрээнд Ажил гүйцэтгэх технолгийн карт, Ажлын байрны эрсдлийн үнэлгээ, Аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаануудыг шинэчлэгдэн боловсруулон мөрдөж осол зөрчилгүй ажилласан.

Хяналтын үйл ажиллагааны дүгнэлт:

Өргөдөл гомдол - Хэрэглэгчдээс ирүүлсэн 2209 өргөдөл гомдлыг ЦЭХ-ээр хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний MNS 5872:2008 стандарт хугацаанд шийдвэрлэж ажилласан.



Хяналт, шалгалт: Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын төлөвлөгөөт хяналт шалгалтаар хуулийн нийцэл 91,7%-тай БАГА эрсдэлтэй үнэлэгдсэн.

Хамгаалалтын зурвас: Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс 71 хэрэглэгчийг хамгаалалтын зурвасаас гаргаж хуулийн хэрэгжилтийг хангаж эрсдлийг бууруулсан.

Хэрэглэгчийн сэтгэл ханамж – Хаан банк нь теллергүй үйлчилгээ нэвтрүүлж АТМ-ээр ЦЭХ-ний төлбөрийг төлдөг болсонтой холбогдуулан Мэдээлэл технологи автомакийн албатай хамтарч НӨАТ-ын баримтыг бүртгэлтэй утас руу мөнгөн дүн сугалааны кодыг sms-ээр илгээдэг болгосон. Ингэснээр НӨАТ-ын баримтыг хэрэглэгчдийн 1,1% авдаг байсныг 100% олгодог болсон.

Нэгдсэн удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны дүгнэлт:

ISO9001:2015, ISO45001:2018 Нэгдсэн удирдлагын тогтолцоо - Нэвтрүүлэх ажлын хүрээнд ОШМИ ХХК-иас зөвлөх үйлчилгээг авч ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, процессын зураглал, мастер жагсаалт болон стандартын хүрээнд шаардагддаг журмуудыг боловсруулан батлуулсан. ISO9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны бодлого, зорилт, баримт бичгийн гарын авлага, материал бэлтгэгдэж хэвлэгдэн нэгж хэсгүүдэд тараагдаж байрлуулсан. ISO9001:2015, ISO45001:2018 Нэгдсэн удирдлагын тогтолцооны стандартыг Нэгдмэл байдлаар нэвтрүүлсэн анхны Эрчим хүчний байгууллага болсон.

ISO9001:2015 ЧУТ стандарт- 2018 оны хийгдсэн зөрүүний шинжилгээний тайлангийн Чанарын удирдлагын стандартын 87 шаардлагаас 21,5 оноо авч нийцэл 24,7 %, байсан байна. 2019 оны 5 сард Чанарын удирдлагын стандартад нийцлийн үнэлгээ хийхэд 85 шаардлагаас 76 шаардлага нийцэж, стандартын шаардлагын нийцэл 86,5% тай байна. Цаашид стандартын шаардлага нийцээгүй зүйлийг хэрэгжүүлж сайжруулахаар төлөвлөн ажилласан.

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК